

CORPUS SCRIPTORUM
Tomus II

Ё.ЖАНЧИВ

СОНГОДОГ МОНГОЛ БИЧГИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ДУРСГАЛУУД

Улаанбаатар
2005

CORPUS SCRIPTORUM
Tomus II

МУИС
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
ТҮРЭГ СУДЛАЛЫН ТЭНХИМ

Ё. ЖАНЧИВ

СОНГОДОГ МОНГОЛ БИЧГИЙН ӨМНӨХ ҮЕИЙН ДУРСГАЛУУД

Эрхилэн хэвлүүлсэн Ц. Баттулга

Улаанбаатар
2005

CORPUS SCRIPTORUM

Tomus II

CENTRE FOR TURKIC STUDIES
SCHOOL OF MONGOLIAN LANGUAGE AND CULTURE
NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

Yo. Janchiv

THE PRECLASSICAL MONGOLIAN MONUMENTS

Edited by Ts. Battulga

ISBN 99929-0-418-6

Copyright © Yo. Janchiv 2005, Ulaanbaatar
All right reserved

ULAANBAATAR
2005

МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн
60 жилийн ойд зориулав.

DDC
494.23
Ж-24

Ёндонжамцын Жанчив

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалууд

Хэвлэлийн эхийг цахим бичүүрт бэлтгэсэн Н.Гэрэлмаа

ADMON ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN 99929-0-418-6

© 2005, Ё.Жанчив

ӨМНӨХ ҮГ

1224/25 оны "Чингисийн чулууны бичиг"-ээс эхлэн XVI зууны төгсгөл үе хүртэлх уйгуржин монгол үсгээр бичигдсэн дурсгалуудыг монголч эрдэмтэд *сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгал* хэмээн нэрлэдэг билээ.

Энэ үеийн дурсгалууд нь эртний болон дундад үеийн монгол хэлний үнэ цэнэтэй баримт хэрэглэгдэхүүн болохын зэрэгцээ тухайн үеийн монголын соёл, утга зохиол, түүх, угсаатны зүй, гадаад харилцаа зэрэг олон салбарыг хамарсан чухал гэрч баримт юм.

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалыг судалж туурвисан гадаадын эрдэмтдийн бүтээл орос, англи, герман, франц, хятад, япон зэрэг олон хэлээр хэдэн арваараа хэвлэгдэн гарсан билээ. Харин уул дурсгалын ихэнхи нь харь орноос олдсон, мөн гадны судлаачдын ном зохиол олдоц муутай байдаг зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас манай эрдэмтдийн судалгааны бүтээл харьцангуй цөөн гарчээ.

Бид энэхүү номдоо сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгал хэмээх ойлголтыг товч тайлбарлаж уул дурсгалуудыг задлан шинжилсэн гадаад дотоодын эрдэмтдийн бүтээлийн тоймыг авч үзлээ.

Ингээд "Чингисийн чулууны бичиг"-ээс XVI зууны төгсгөл үе хүртэлх үеийн нийт 210 дурсгалын бүртгэлийг оруулав. Ийн бүртгэл жагсаалт үйлдэхдээ дурсгал нэг бүрийг товч тодорхойлж тухайн дурсгалын судлалаар гарсан эрдэмтдийн бүтээлийн ном зүйг дор дор нь хавсаргасан болно.

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалыг судлах үлгэр болгон Ил хаан Аргунаас Францын IV Гоо Филипп ванд илгээсэн 1289 оны захидлыг латинаар галиглаж, шинэ үсгээр хөрвүүлэн, зарим үг хэллэгийг нь товч тайлбарлалаа.

Номын төгсгөлд судалгааны бүтээлийн "Ерөнхий номзүй"-г кирилл үсэг, монгол бичиг, латин үсэг, хятад, япон хэлээр хэмээн ангилан жагсаав.

Цаашид нягтлан судлах хүмүүст тус дэм болохын үүднээс гол гол дурсгалын эхийн гэрэл зургийг хавсаргасан болно.

Жич, Бид номоо энэ чиглэлээр бүтээл туурвиж буй академич Д.Төмөртогоод үзүүлэхэд хэвлэн гаргахыг зөвлөж урам хайрлав. Д.Төмөртогоо багшийн Тайваньд хэвлэгдэж буй ном сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудын латин галиг, үгийн хэлхээ орж байгаа тул бид бүтээлдээ эхийн галиг хийхийг зорьсонгүй, зөвхөн судалгааны номзүй, эхийн гэрэл зураг нийтлүүлэхээр шийдсэн билээ.

Номын эхийг цахим тооцоолуурт нэг бүрчлэн нягт нямбай оруулж өгсөн МУИС-ийн Монгол хэл соёлын сургуулийн Түрэг судлалын тэнхимийн багш Н.Гэрэлмаа, дурсгалуудын гэрэл зургийг цахимд оруулж тусалсан тус сургуулийн Монгол хэлний тэнхимийн багш, докторант Т.Жамьянсүрэн, уул бүтээлийг ариутган шүүсэн Түрэг судлалын тэнхимийн эрхлэгч, доктор Ц.Баттулга, зохиолын талаар санал бодлоо харамгүй хайрласан ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Р.Мөнхтулга нарт чин сэтгэлийн талархалаа дэвшүүлье.

Бидний энэ ажилд алдаа эндэгдэл байгаа нь эргэлзээгүй тул үзэх мэргэд тольдон болгоож, санал бодлоо хайрлан соёрхоно уу.

Зохиогч

1. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалын учир

Аливаа улс үндэстний хэлийг аман ярианы хэл, бичгийн хэл хэмээн хоёр хуваах бөгөөд бичгийн хэл нь ярианы хэлнээ тулгуурлан хожуу үүсч хэлбэршин тогтдог байна. Бичгийн хэл бол илүү нарийн дүрэм журамтай, харьцангуй тогтвортой хэл юм[1].

Монголчууд хятан (их, бага), монгол, дөрвөлжин (1269), тод (1648), соёмбо (1686), хэвтээ дөрвөлжин, вагиндра (1907), латин, кирилл[2] зэрэг олон зүйл бичиг үсэг зохион хэрэглэж ирсэн бөгөөд эдгээр бичгээр тэмдэглэгдсэн дурсгалууд нэгдмэл монгол бичгийн хэлний олон зүйл хувилбар болохоос бус тус тусдаа биеэ даасан бичгийн хэл биш билээ.

Эдгээр бичиг үсгийн дотроос өнө удаан жил, нэн өргөн хүрээнд, үлэмж тогтвортой хэрэглэгдсэн бичиг бол монгол үсэг болой.

Монгол бичиг цагийн шалгуурыг амжилттай даван туулж бидний үед уламжлан ирсний учир гэвэл, сэтгэлгээний ихээхэн хийсвэрлэлийн бичиг бөгөөд үе үеийн эрдэмтэн мэргэдийн оюун ухааны охь дээжийг өөртөө шингээснийх буй за. Өөрөөр хэлбэл монгол хэлний авиазүй, авиалбарзүй, эгшиг зохицох ёс хийгээд үг бүтэхүйн ёсноо нийцсэн төдийгүй нийт монгол туургатны хэл аялгууны хамгийн нийтлэг онцлогийг сайтар тусгаж чадсан байна.

Монгол бичгийн хэлний гарал үүсэл, гол гол онцлог, түүхэн хөгжил зэргийг эрдэмтэн мэргэд судлан шинжилж, олон арван бүтээл туурвисаар ирсэн авч одоо болтол бүрэн дүүрэн шийдвэрлээгүй асуудлууд байсаар байна. Тухайлбал, монгол бичгийн үүсч буй болсон он цагийн талаар дараахи домог хийгээд хэдэн зүйл санал байдаг. Үүнд;

1. 1243 онд Сажа бандид Гунгаажалцан (1182-1251) "...монгол улсын үсгийг хэдрэгний дүрсээр нь эр, эм, эрс гурваар чанга, хөндий ба саармаг гурваар зохиосон болой"[3] хэмээн XVIII зууны үед Монлам рабжинба Данзандагва бичжээ.
2. "Юань улсын судар"-ын 124-р боть дахь "Тататунгаагийн намтар"-ын нэгэн мэдээг үндэслэн монголчууд XIII зууны эхэн үед буюу 1204 онд уйгураас монгол үсгийг авч хэрэглэх болсон гэх үзлийг өрнө дорны олон судлаач баримталдаг байна[4].
3. 925 онд зохиогдсон хятаны бага бичгийг уйгур бичиг байсан, монгол бичгийн хэл хятанчуудын дунд үүсч буй болоод эндээс бусад монгол овог аймгийн дунд түгэн дэлгэрсэн гэж Л.Лигети, Л.Викторова нарын зэрэг судлаачид үздэг байна[5].

---

[1] Д.Төмөртогоо, Монгол бичигийн хэл, "Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудлууд", УБ., 2002, (тал. 290-322), 290.

[2] Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2001, 300 тал.

[3] Т.Пагва, Зүрхэн тольтын тайлбарыг судалсан тухай тэмдэглэл, УБ., 1957, (64 тал), 24.

[4] Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, Том.I, М.,1953, (240сс.), 14; E.Haenisch, Die Geheime Geschichte der Mongolen aus einer Mongolischen Niederschrift des Jahre 1240 von der Insel Köde'e im Kerülen = Fluss, Erstmalig überseβt und erläutert. Leipzig, 1948, 183; N.Poppe, Khalkha-mongolische Grammatik, Wiesbaden, 1951, 7; Dobu, Uyiγurjin mongol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), I-II; Bulaγ, Mongol üsüg bičig-ün tobči teüke, ÖMAKQ, 1983, 296 tal-a; Ö.Manduqu, Mongγol ündüsüten-ü üsüg bičig-tei boluγsan čaγ üy-e-yin tuqai, "Mongγol kele, mongγol teüke", 1983, №1, 1-12; В.И.Истрин, Возникновение и развитие письма, М.,1965.

[5] Л.Лигети, Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, Том.I, М.,1953 номын шүүмж, "ХЗС", t.YIII, 1970, (сс. 321-339), 328; Л.Викторова, К вопросу о найманской теории происхождения монгольского литературного языка и письменности (XII-XIII вв), Уч.Зап.ЛГУ,

4. Монголчууд уйгур үсгийг 1204 оноос өмнө буюу, нэлээд өмнө авсан гэж үздэг эрдэмтэд цөөн бус буй[6].

Эдгээрийн дотроос дөрөв дэх санал бусдаас илүү үндэслэлтэй мэт санагдаж байна. Уг саналын гол үндэс болсон хэдэн зүйлийг хүлээн авууштай бодогдоно. Харин нарийн тодорхой он цаг тогтоох боломж бараг үгүй байх аа[7].

Нөгөө нэг маргаантай зүйл бол монгол бичиг хэдий үеийн ямар аялгуунаа суурилан зохиогдсон бэ? гэдэг асуудал юм. Үүнийг анх академич Б.Я.Владимирцов анхааранд, тухайн цаг үедээ бусад аймгаас илүү соёлтой, мөн Уйгур, Хар-хятай, Хятад, Тангуд, Зүрчид зэрэг Азийн соёлт улс түмэнтэй өргөн харилцаатай байсан Хэрэйд, Найман нарын аялгуунаа монгол бичгийн хэл хэвшин тогтсоныг хожим Чингис хаан эзэнт гүрнийхээ бэлэн зэлэн бичгийн хэл болгож авсан гэдэг санал дэвшүүлжээ[8]. Түүний энэ саналыг Н.Н.Поппе, Г.Д.Санжеев нар ерөнхийдөө дэмжсэн байдаг[9].

Монгол бичгийн хэл хятанчуудын дунд үүсч бий болсон гэсэн өөр нэг саналыг академич Л.Лигети дэвшүүлж Л.Викторова зэрэг эрдэмтэд дэмжсэн бөлгөө[10]. Энэ талаар академич Д.Төмөртогоо "...Ийнхүү монгол бичигийн хэлний суурь аялгууны талаар *Найманы онол*, *Хятаны онол* гэсэн хоёр өөр онол гарч ирээд байна. Ер монгол бичигийн хэлний үүсэл гаралын тухай асуудал нь угтаа монгол овог аймгуудын удам угсааны хамаадалтай нягт холбоотой билээ. Гэтэл нэг талаас найманчуудын удам угсааны тухай асуудал, нөгөө талаас хятанчуудын хэл соёлын тухай асуудал бүрэн судлагдаагүй байгаа өнөө үед монгол бичигийн хэлний гарал үүсэл, найман хятантай хэрхэн холбогдох тухай асуудалыг баримжаалан тогтоох боломжгүй байна" гэж бичсэнтэй бид бүрэн санал нийлж байна[11].

Монгол бичиг нь согд гаралтай уйгур үсгээс уламжилсан бөгөөд тэрхүү согд үсэг нь эртний арамей бичгээс, энэ нь цаашилбал, дэлхийн анхны авианы бичиг болох финик цагаан толгойгоос уг сурвалжтай гэдэг нь баримтаар нутлагдсан зүйл хэмээн үзэж болно. Гэтэл сүүлийн үед монгол бичгийг уйгураас аваагүй, харин уйгур, монгол хоёр согдоос зэрэг авсан гэж үздэг

серия Вост.наук. Вып.12. №305, 1961, (сс. 137-144), 154; Л.Викторова, Монголы. Происхождение народа и истоки культуры, Л.,1980, (223 сс), 151-152.

[6] Rinčen, Mongγol üsüg-ün γarul kögjil, MTKB, 1958, №5, (tal-a, 5-26), 11; Bousiyang, Mongγol üsüg bičig-ün uqaγan, ÖMSKKQ, 1984, (222 tala), 21-26; Danzan, Uyiγurjin mongγol bičig, "Erdem sinjilegen-ü ögülel-üd", ÖMAKQ,1990, 100; Danzan, Mongγol bičig-ün soyul-un teüken surbulji, ÖMAKQ, 1999, (138 tal-a), 121; Д.Төмөртогоо, Монгол хэлний түүхэн хэлзүй, УБ.,1992, (219 тал), 37-38; Д.Төмөртогоо, Монгол бичгийн хэл, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал), 292-293; Г.Сүхбаатар, Сяньби, УБ., 1971, (216 тал), 114; Ц.Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, УБ.,1981, (168 тал) 11; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2001, (300 тал), 25;

[7] Ё.Жанчив, Монгол бичиг, (гар бичмэл), 1-7.

[8] Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия, Введение и фонетика, Л.,1929, (XII+436 стр.) 20; Б.Я.Владимирцов, Монгольские литературные языки, Зап.Ин-та Вост.АН, t.1, 1931, (сс.1-17), 6.

[9] Н.Н.Поппе, Грамматика письменного монгольского языка, М-Л.,1937, (196стр), 13; Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, Т.1, М.,1953, (240стр), 14-15.

[10] Л.Лигети, Рец. Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, Т.1, М.,1953, ВЯ.5 (1959), (сс.133-139), 135; Л.Викторова, К вопросу о найманской теории происхождения монгольского литературного языка и письменности (XII-XIII вв), Уч.Зап.ЛГУ,серия Вост.наук,Вып.12, №305, Л.,1961, (сс.137-155), 155; Л.Л.Викторова, Монголы. Происхождение народа и истоки культуры, Л.,1980, (223 стр.) 151-152.

[11] Д.Төмөртогоо, Монгол бичигийн хэл, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (тал.290-322), 294-295.

судлаачид бий болов. Тухайлбал, түүхийн ухааны доктор Г.Сүхбаатар агсан 1971 онд хэвлүүлсэн "Сяньби" номдоо, 1230 онд Монголоор жуулчилсан Сүн улсын элчин Пэн Да-Я, Сюй-Тин нарын тэмдэглэлд монголчууд гурван янзын бичиг хэрэглэж байсан тухай өгүүлсэн байдгийг дурдаад энэ нь уйгуржин монгол, хятад, уйгар бичиг байсан гээд "...Уйгар бичгийн үүслийн талаар А.Махмутов бичихдээ: "Барагцаалбал V зууны үед Бешбалык баянбүрдээр нутаглаж байсан уйгар нар согд цагаан толгойноос уйгар үсэг авчээ" гэжээ. Жужан нар ч мөн V зууны үед бичиг авсан бололтой. Ингэхлээр согд бичгийг уйгар, монгол хоёр нэгэн зэрэг авсан байж болох юм" гэсэн таамаглал дэвшүүлсэн билээ[12].

Профессор Ц.Шагдарсүрэн 1981 онд нийтлүүлсэн "Монгол үсэг зүй" номдоо дээрх таамаглалыг лавшруулан нутлахыг чармайсан байна. Тухайлбал, Сяньби хэлний нэгэн аялгуу болох табгач хэл нь эртний монгол хэлний байдлыг тусгажээ хэмээн дүгнэсэн акад. Л.Лигетийн саналд [13] тулгуурлан "...монгол бичгийн хэл нь табгач хэлний онцлогтой их л ойр байгаа нь XIII зуунд монгол бичгийг уйгараас авсан гэж үзэхэд эргэлзээ төрүүлж байгаа юм"[14] гэжээ. Мөн цааш нь, уйгар монгол хоёр бичигт зөрөөтэй тэмдэглэдэг таван үг жагсаагаад (монгол jrlγ; уйгар jrliγ; монгол šastir; уйгар šastr гэх мэт) энэ нь "...уйгарын уламжлалын шууд нөлөө гэж үзэхэд эрхгүй эргэлзээ төрүүлж байгаа юм"[15] хэмээн дүгнэжээ. Ингээд монгол уйгур хоёр хэлэнд байгаа шашны ихэнх нэр томъёо согдоор дамжин орж ирсэн байдаг тухай академич Б.Я.Владимирцовын дүгнэлт[16], согдын мэргэн багш нар уйгур хийгээд монголчуудад үсэг бичиг унших ба бурхны номыг өөрийн хэлээрээ орчуулах ёсыг заасан гэсэн Г.И.Рамстедт[17], Зава Дамдин[18] нарын баримт сэлт, эрт цагт нэг улс нөгөөгөөсөө шашин номын тусгай зорилгоор бичиг үсэг авдаг байсан тухай эрдэмтэн В.Истриний онолын дүгнэлт[19] зэрэгт тулгуурлан "...Монголчууд XIII зууны үед согд үсгийг уйгараас дам авч хэрэглэсэнгүй, харин VI-VII зууны үед Монгол, Уйгар хоёр одоогийн Тажикийн дээд өвөг Согд нараас нэгэн зэрэг бичиг үсэг авсан байж болох баримт гарч байна. Хэрэвзээ Уйгарууд согдоос V зуунд бичиг үсэг авсан гэж нуталж байгаа А.Махмутовын судалгааг дээрхи баримттай холбож үзвэл Монголчууд бичиг үсэг авсан он цаг даруй нэгэн зуун жилээр урагшлах юм"[20] гэсэн дүгнэлт хийжээ. Зохиогч энэхүү шинэ саналаа 2002 онд хэвлүүлсэн "Монголчуудын үсэг бичигийн товчоон" номдоо дахин нутлан өгүүлсэн байна[21].

Иймхүү V зууны үед монголчууд Согдоос бичиг үсэг авсан гэсэн Г.Сүхбаатар, Ц.Шагдарсүрэн нарын таамаглал монгол үсэг бичгийн гарлыг хамгийн их урагшлуулсан таамаглал бөлгөө.

---

[12] Г.Сүхбаатар, Сяньби, УБ.,1971, (216 тал), 114.

[13] L.Ligeti, Le Tabghatch un dialecte de la langue Sien-pi, "Mongolian Studies", Budapest, 1970, 265-308; Л.Лигети, Табгач хэл Сяньбийн нэгэн аялгуу болох нь, ХЗС, t.YII, УБ.,1970, 227-244.

[14] Ц.Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, УБ.,1981, (168 тал), 10.

[15] Мөн ном, 10.

[16] Б.Я.Владимирцов, Mongolica, Об отношении монгольского языка к индо-европейским языкам Средней Азии, Зап.Кол.Вост. №1, Л.,1925, 305-341.

[17] G.I.Ramstedt, Uyiγur ulus-un quriyangγui teüke, УБ.,1922, 11-12.

[18] Зава Дамдин, Хор чойнжүн, (төвд-монгол хадмал судар).

[19] В.И.Истрин, Возникновение и развитие письма, М.,1965, 536.

[20] Ц.Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, УБ.,1981, (168 тал), 11.

[21] Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2001, (300 тал), 22-28.

Эдүгээ олдоод байгаа монгол бичгийн хамгийн анхны дурсгал 1224/1225 оных байгаа тохиолдолд монгол үсгийг хэрэглэж эхэлсэн он цагийг урагшлуулсан саналууд зөвхөн таамаглал хэвээр л үлдэх болно.

Монголчууд уйгураас үсэг бичиг авсан уу, эсвэл согдоос уйгур нартай нэгэн зэрэг авсан уу гэдгийг согд, уйгур, монгол гурван зүйл бичгийг үсэгзүй, зөв бичихзүйн үүднээс нарийн нягт харьцуулан шинжилсний үр дүнд шийдвэрлэвэл зохих буй за.

Аливаа бичгийн хэлний хөгжлийн түүхийг цуваа цагийн үүднээс нягтлан судлахын тулд тухайн хэлний хөгжлийн түүхнээ гарсан гол гол хэвшлүүдийг судлан тогтоож, түүнд тулгуурлан үечлэн хуваадаг билээ. Монгол бичгийн хэлний хөгжлийн түүхийг олон эрдэмтэн анхааран шинжилж, үечлэн хуваасаар иржээ.

Хамгийн анх академич Б.Я.Владимирцов 1921 онд хэвлүүлсэн бүтээлдээ монгол бичгийн хөгжлийн түүхийг нэн эртний үеэс XIII зууны эцэс хүртэл 1-р үе, XIV зууны эхэн үеэс XVI зууны эцэс хүртэл 2-р үе, XVII зууны эхэн үеэс хойшхи үеийг 3-р үе хэмээн 3 үе шат болгон ангилсан билээ[22]. Тэрбээр хожим 1929 онд хэвлүүлсэн алдарт хэлзүйдээ;

1. Эртний үе (Үл мэдэгдэх үеэс XIV зууны эхэн үе) Энэ үеийн бичиг голдуу улсын албан харилцаанд хэрэглэгдэж байв.
2. Дундад үе (XIV зууны эхэн үеэс XVI зууны сүүл хагас). Энэ үе болж ирэхэд албан харилцаанд хэрэглэгдэхээс гадна бурхан шашны ном зохиол орчуулахад өргөнөөр хэрэглэх болжээ. Өөрөөр хэлбэл, энэ үед төвд болон уйгурын санваартан нарын удирдлагаар буддын шашны олон ном зохиолыг монгол хэлээр орчуулан хэвлэжээ. Эхний хоёр үеийн туршид зурлагын зарим нэг өөрчлөлтийг эс тооцвол, уйгур бичгийг бараг тэр хэвээр нь хэрэглэж байжээ. Иймч учраас энэ үеийн бичгийг уйгуржин монгол үсэг гэж нэрлэдэг.
3. Шинэ үе (XVI зууны эцэс, XVII зууны эхэн үеэс эдүгээ хүртэл). Энэ үед үсэг бичгийн хувьд ч, үг хэлний хувьд ч эрс өөрчлөгдөж хуучирсан, ойлгомжгүй болсон үг, нэхцөл хэрэгцээнээс гарч, ардын аман аялгууны элементүүд нэвтэрч төвд үг ч олноороо орж ирсэн байна. Олонх үсгийн зурлага өөрчлөгдөж, одоогийн хэлбэрээ аажмаар олж эхэлжээ. Иймээс энэ үеийг сонгодог бичгийн үе гэдэг[23] хэмээн бичсэн байна.

Профессор Н.Н.Поппе 1937 онд хэвлүүлсэн "Грамматика письменного монгольского языка" хэмээх бүтээлдээ;

1-р үе, XII зуунаас XVII зуун хүртэлх үе

2-р үе, XVII зуунаас Октябрийн хувьсгал хүртэлх үе

3-р үе, Октябрийн хувьсгалаас хойшхи үе хэмээн 3 үе болгосон[24] бөгөөд хожим нь нэмэн засварлаж англи хэлээр уг номоо хэвлүүлэхдээ мөн л 3 үе шат болгон хуваажээ[25].

Хожим монгол бичгийн хэлний хөгжлийн тусгайлсан ангиллыг Г.Дёрфер (1964), А.Лувсандэндэв (1972), М.Н.Орловская (1986), Г.Данзан (2002) нар хийж гурав болон дөрвөн үе шат болгон хуваасан байдаг билээ[26].

---

[22] Б.Я.Владимирцов, О трех периодах монгольского письменного языка, "Монгольский сборник рассказов из Pancatantra", Пб.,1922. 42-54.

[23] Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия, Введение и фонетика, Л.,1929, (XII+436 стр.), 21-24.

[24] Н.Н.Поппе, Грамматика письменного монгольского языка, М-Л., 1937, (196 стр), 13.

[25] N.Poppe, Grammar of Written Mongolian, Wiesbaden, 1954, (195pp), 2-3.

Профессор Ц.Шагдарсүрэн монгол бичгийн дурсгалыг:

1. Дундад эртний үе (Хамгийн анхны дурсгалаас XVI-XVII зуун). Энэ үеийн үсгийн зурам байдал нь согд үсэгтэй нэлээд ойр, уйгар үсгээс бараг ялгагдахгүй.
2. Шинэ үе (XVI-XVII зуунаас өдгөө хүртэлх үе). Одоогийн бидний бичигтэй ойр хэмээн хоёр үе болгон үзжээ[27].

Өвөр монголын судлаач Дов монгол бичгийн хөгжлийг хоёр үед хуваагаад, эртний үед уг үсгийн зурлага, дүрэм журам зэрэг нь цөм уйгур үсэгтэй адил байсан, 2-р үе болоход "Монгол үсэг", "Тод үсэг" гэсэн хоёр салбарт хуваагдаж, жинхэнэ орчин үеийн монгол үсэг буй болсон гэж үзжээ. Ийнхүү хоёр үе болгохдоо Мин улсын эцэс ба Чин улсын эхэн үеийн наана цаана гэдгээр нь зааглан авч үзнэ. "Ганжуур ном"-ын монгол орчуулгаар орчин үеийн монгол бичгийн үе эхэлсэн хэмээн бичсэн байдаг[28].

Хэдийгээр монгол бичгийн хэлний хөгжлийн түүхийг дээр дурдсанчлан олон янзаар ангилсан байх боловч өдгөөгийн дэлхийн монгол судлалын хүрээнд;

1. Сонгодог монгол бичгийн хэлний өмнөх үе (Монгол хэлний нэгэн аялгуун дээр үндэслэсэн бичгийн хэл үүсэн бүрэлдсэн эрт цагаас эхлээд XVI-XVII зууны үе хүртэл)
2. Сонгодог монгол бичгийн үе (XVI-XVII зууны үеэс өнөөг хүртэл) хэмээн хоёр үе шат болгон ангилах явдал түлхүү ажиглагддаг билээ.

Эрдэмтэд монгол бичгийн хэлний хөгжлийн түүхийг бодтой тусган ангилсаар ирсэн боловч цаг хугацааны хувьд хэт огцом хуваасан, бичгийн хэлний зүй тогтлыг тухайн үеийн улс төр, үзэл сурталтай хутгасан, сонгодог монгол бичгийн үе хэмээх ухагдахуун нь зарим талаар эргэн няглуушгай зэрэг зарим өрөөсгөл тал байгааг академич Д.Төмөртогоо, профессор И.де.Рахевильц, профессор Ц.Шагдарсүрэн, судлаач Д.Заяабаатар нар зөв зүйтэй ажиглан тэмдэглэсэн зүйл байдгийг онцлон тэмдэглэе[29].

Ялангуяа сонгодог монгол бичгийн хэл хэмээх ойлголтын тухайд цаашдын судалгаанд анхаарвал зохих зарим онцлог байдгийг профессор Ц.Шагдарсүрэн жишээ баримтаар тодруулан авч үзэж, хэд хэдэн чухал дүгнэлт хийжээ[30].

---

[26] Д.Заяабаатар, Монгол бичгийн хэлний түүхэн хөгжлийг судлах асуудалд, МУИС,МХСС, "Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг", боть.XIX (193)УБ., 2003, (тал. 53-66), 58-59.

[27] Ц.Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, УБ.,1981, (168 тал), 10; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2001, (300 тал), 29.

[28] Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ,1983, (695 tal-a), V-VI.

[29] Д.Төмөртогоо, Монгол хэлний түүхэн хэлзүй, УБ., 1992, (219 тал), 36-37; Д.Төмөртогоо, Монгол бичигийн хэл, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", (тал. 290-322), 297-298; Igor de Rachewiltz, Some Reflections on So-called Written Mongolian, STM,(Festschrift Manfred Taube), Swisttal-Odendorf, 1999, (pp.235-246), 242-243; Ц.Шагдарсүрэн, Сонгодог бичигийн хэл буюу монгол судрын хэлний зарим онцлогоос, "Acta Mongolica", vol.2(208), МУИС-ийн ЭШБ,УБ., 2003, (тал.17-30), 18-29; Д.Заяабаатар, Монгол бичгийн хэлний түүхэн хөгжлийг судлах асуудалд, МУИС, МХСС, МС-ын ЭШБ, боть. XIX (193), УБ., 2003, (тал. 53-66), 59-60.

[30] Ц.Шагдарсүрэн, Монгол хэлний хөгжлийн эртний үе, түүнийг судалсан тойм, "Эртний монгол хэлний судлал, (Монголын судлалын сонгомол өгүүллийн эрхи, I хэлмэли, Монгол хэл бичиг, II дэвтэр)", УБ., 1999, 67-125; Ц.Шагдарсүрэн, Сонгодог монгол бичгийн хэл буюу монгол судрын хэлний зарим онцлогоос, Acta Mongolica, vol.2(208), УБ., 2003, 17-30.

Судлаач Д.Заяабаатар "...Монгол бичгийн хэлийг үечлэхэд зөвхөн нэг талын өнцгөөс харах бус үсгийн тиг зурлага, зөв бичихзүйн онцлог, хувьсал өөрчлөлт, үгийн хэлбэрзүйн хэлбэржилт, өгүүлбэрийн зохион байгуулалт, найруулгын хэв маяг, үгийн сангийн бүрэлдэхүүн зэрэг нийтэм цогц байдлыг харгалзан үзэх нь чухал болов уу"[31] хэмээн тэмдэглэсэнтэй бид санал нэг байна.

"...Дорно дахины их таван ухааны хэдэн мянган оргил бүтээлийг багтаасан 108 боть "Ганжуур", 225 боть "Данжуур"-ыг XVIII зууны үед орчуулан гаргасан нь монгол бичгийн хэл чухам л сонгодог бичгийн хэлний зиндаанд хүрсний жишээ бодтой баримт болж байна" [32] хэмээн академич Д.Төмөртогоо тэмдэглэжээ.

Монгол бичгийн хэлний үе үеийн бодот дурсгалууд болон эрдэмтэн судлаачдын бүтээл сэлтээс үзэхүл сонгодог монгол бичгийн өмнөх үе гэдэг нь XIII зууны эхэн үе (тухайлбал, 1224/25 оны "Чингисийн чулууны бичиг")-ээс XVI зууны төгсгөл хүртэлх үеийг хамарч байгаа билээ.

Сонгодог бичгийн өмнөх дурсгалууд нь зохиогдсон он цагийн хувьд дундад үеийн монгол хэлний үед хамаарах боловч авианзүйн онцлог шинжээрээ эртний монгол хэлний сүүл үеийн онцлогийг тусгасан болохыг эрдэмтэд тэмдэглэсэн байдаг [33] . Тухайлбал, судлаач Д.Заяабаатар "...өдгөө бидний мэдлэгийн хирээр монгол бичгийн дурсгалууд цаг хугацааны хувьд XIII зуунаас хойшхи буюу монгол бичгийн хэлний хөгжлийн дунд үед хамаарч буй ч тэдгээрийн хэлний байдал нь дундад үеийн монгол хэлний дорнод аялгууны дурсгал болох "*Монголын нууц товчоон*", дөрвөлжин бичгийн хэл хийгээд өрнөд аялгууны дурсгал болох "*Мукаддимат-Ал-Адаб*", "*Стамбулын толь*" зэргээс ихээхэн ялгаатай байгааг хялбар тогтоож болно"[34] хэмээн бичжээ. Ийм учраас сонгодог бичгийн өмнөх дурсгалууд нь эртний монгол хэлний онцлогийг тодруулахад чухал эх хэрэглэгдэхүүн болдог билээ.

Хэдий тийм боловч сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгал үгийн сан, өгүүлбэрзүй, найруулгазүй зэрэг олон шинжээрээ дундад үеийн монгол хэлний онцлогийг тусгасан байдгийг олон жишээ баримтаар нутлан харуулж болох юм. Түүнчлэн, энэ үеийн бичгийн дурсгалуудад эгшгийн ижилшил, уруулшил, гийгүүлэгчийн сулрал зэрэг дундад үеийн монгол хэлний авианзүйн онцлог ямар нэг байдлаар туссан байдаг тухай академич Д.Төмөртогоо бичсэн буй[35]. Иймийн тул, дундад үеийн монгол хэлний дурсгал уйгуржин монгол, дөрвөлжин, нангиад, араб зэрэг 4 зүйлийн үсгээр тэмдэглэгдсэн байдгийг онцлон тэмдэглэвэл зохино.

1224/25 оны *Чингисийн чулууны бичиг*, 1240 оны *Төрэгэнэ хатны зарлиг*, 1246 оны *Гүюг хааны тамгын бичиг* зэрэг сонгодог бичгийн өмнөх дурсгалуудыг нэг бүрчлэн нягтлан үзэхүл тэдгээр нь ихэд боловсорсон бичгийн хэлээр бичигдсэн байдаг бөгөөд XIII-XIV зуун гэхэд нарийн тогтсон зөв бичихзүй, хэвшсэн найруулга бүхий боловсон бичгийн хэл болсон байсан нь

---

[31] Д.Заяабаатар, Монгол бичгийн хэлний түүхэн хөгжлийг судлах асуудалд, МУИС, МХСС, МС-ын ЭШБ, боть.XIX(193), УБ.,2003, (тал. 53-66), 60.

[32] Д.Төмөртогоо, Монгол хэлний түүхэн хэлзүй, УБ.,2002, (219 тал), 47.

[33] N.Poppe, Ancient Mongolian, "Tractata Altaica, Denis Sinor Sexagenerio Optima de Rebus Altaicis Merito Dedicata", Redigerunt Walther Heissig, John R.Krueger, Felix J. Oinas, Edmond Schütz, Wiesbaden,1976, (pp.463-478), 464; Д.Төмөртогоо, Монгол хэлний түүхэн хэлзүй, УБ.,1992, (219 тал), 5.

[34] Д.Заяабаатар, Монгол бичгийн хэлний түүхэн хөгжлийг судлах асуудалд, МУИС, МХСС, МС-ын ЭШБ, боть.XIX(193), УБ., 2003, (тал. 53-66), 62.

[35] Д.Төмөртогоо, Монгол бичгийн дурсгалууд эгшиг авианы ижилсэл, уруулшил хийгээд хоёр эгшгийн дундах зарим гийгүүлэгчийн сугарлыг тусгасан нь, ХЗС, t.YI, УБ.,1969, 79-82.

тодорхой харагддаг билээ. Гэвч сонгодог бичгийн өмнөх дурсгалуудын хэлний "...бичлэгийн дүрэм нь бүрэн жигдрээгүй, үгийн сан нь харьцангуй хязгаарлагдмал, хэл найруулгын өнгө аясын нарийн ялгарал тодорхой гараагүй, харь хэлний үгсийг нарийн тэмдэглэх арга зарчим гүйцэд боловсроогүй, ...орчуулгын зохиолуудын дотор харь хэлний өгүүлбэрийн бүтцийн өвөрмөц онцлогт хэт баригдсан, монгол хэлнийхээ өгүүлбэрийн ерөнхий бүтэц, үгсийн тогтсон дарааллыг гажуудуулсан"[36] зэрэг өрөөсгөл тал ажиглагддаг хэмээн академич Д.Төмөртогоо тэмдэглэсэн буй.

Тэмдэглүүштэй нэгэн зүйл буй нь, сонгодог бичгийн өмнөх үеийн (XIII-XVI зуун) онцлогийг тусгасан бичгийг *уйгуржин монгол бичиг*, сонгодог бичгийн үеийнхийг *монгол бичиг* хэмээн зарим хүмүүсийн ялган хэрэглэж байгааг бид хувьдаа зөв зүйтэй гэж үзэж байна. Учир нь, сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалуудын үсгийн тиг зурлага зэрэг нь хожуу үеийн бичгээс илт ялгаатай, уйгур үсгийн бичлэгийн онцлогтой их ойр байдаг билээ. Гэтэл XYII зуунаас хойш үе болж ирэхэд монгол үсгийн тиг зурлага өөрчлөгдөж, зөв бичихзүй хэлбэршин тогтож ирсэн нь тодорхой мэдэгддэг. Учир иймээс, "*Чингисийн чулууны бичиг*" (1224), "*Өлзийт султаны захидал*" (1305), "*Инду вангийн гэрэлт хөшөөний бичээс*" (1362), "*Ачалат ном*"(XIV зуун) зэрэг нь уйгуржин монгол үсгээр, "*Цогтын хадны бичиг*" (1624), Лувсанданзаны "*Алтан товч*", Жамбын "*Асрагч нэртийн түүх*", Инжаннашийн "*Хөх судар*" сэлт нь монгол бичгээр тус тус бичигдсэн бөлгөө.

2. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалын судалгааны товч тойм

XIX зууны тэргүүн хагасаас эхлэн монгол бичгийн хэлийг судалсан дорвитой бүтээлүүд гарч эхэлсэн байна. Эдний дундаас Оросын ШУА-ийн жинхэнэ гишүүн И.Я.Шмидтийн 1831 онд германаар, 1832 онд орос хэлээр тус тус нийтлүүлсэн "Монгол хэлний зүй"[37] хэмээх ном Европ дахинд монгол хэл судлалын үүд хаалгыг нээсэн төдийгүй, монгол хэлийг Грек-Ромын хэл шинжлэлийн аргаар судлахын эхлэлийг тавьснаараа чухал ач холбогдолтой бүтээл болжээ.

Уг зохиолд дэвшүүлсэн олон асуудал өдий хүртэл өөрчлөгдөлгүй шахам явж ирсэн байна. И.Я.Шмидтийн энэ бүтээл дараа дараагийн олон арван ном зохиолд үлгэр дууриал болсон юм.

Мөн 1849 онд Казань хотноо хэвлэгдсэн Алексей Бобровниковын "Монгол халимаг хэлний зүй"[38] нь монгол хэлийг өөрийнх нь дотоод зүй тогтлын үүднээс судалсан тул одоо хүртэл ач холбогдлоо алдаагүй сайн зохиолд тооцогддог билээ.

XX зуун гарсаар Финийн алдарт монголч Г.И.Рамстедтийн "Монгол бичгийн хэл, хүрээний аман аялгуу хоёрыг авиан зүйгээр харшуулах нь"[39]

---

[36] Д.Төмөртогоо, Монгол бичигийн хэл, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (тал. 290-322), 300.

[37] I.J.Schmidt, Grammatik der mongolischen Sprache, SPb., 1831, 191 ss; И.Я.Шмидт, Грамматика монгольского языка, СПб.,1832, VII+184 сс.;

[38] А.А.Бобровников, Грамматика монгольско-калмыцкого языка, Казань, 1849, 409 сс.

[39] G.J.Ramstedt, Das Schriftmongolische und die Urgamundart phonetisch Verglichen, JSFOu 21: 2, 1903, 1-56; Г.И.Рамстедт, Сравнительная фонетика монгольского письменного языка и халхаско-ургинского говора, СПб.,1908, 65 сс; Г.И.Рамстедт, Монгол ном бичгийн хэл хүрээний аман аялгуу хоёрыг авиан зүйгээр харшуулсан нь, (Г.Лувсанцэрэн герман хэлнээс орчуулав), ХЗ, IV боть, УБ.,1967, 115-169.

хэмээх монгол хэл шинжлэлд шинэ улирлыг нээсэн туурвил хэвлэгдэн гарчээ. Уг бүтээл анх удаа монгол бичгийн хэлийг амьд аялгуутай харшуулан судалснаараа, өөрөөр хэлбэл, монгол хэлний нутгийн аялгууны судалгааг эхэлснээрээ үнэ цэнэтэй юм.

Г.И.Рамстедтийн мөрөөр Орос-Зөвлөлтийн нэрт монголч, академич Б.Я.Владимирцов замнаж, "Монгол бичгийн хэл болон халхын аман аялгууны харьцуулсан хэл зүй" (Удиртгал, Авиан зүй)[40] хэмээх монгол хэл шинжлэл төдийгүй алтайн судлалд жинтэй хувь нэмэр оруулсан бүтээлээ хэвлүүлжээ.

Үүнээс хойш Н.Поппе, Г.Д.Санжеев, Б.Ринчен нарын тулгуур бүтээлүүд ар араасаа хэвлэгдэн гарлаа[41].

Түүнчлэн Г.Д.Санжеев, Н.Поппе, Ж.Надмид[42], Ц.Шагдарсүрэн[43] нар өөр өөрсдийн номдоо монгол бичиг болоод монгол бичгийн хэлний онцлогийг судалж, үнэ цэнэтэй санал, дүгнэлт олныг гаргасан билээ.

Дээр дурдсан зохиолууд ихэвчлэн сонгодог монгол бичгийн хэлийг судлахад зориулагджээ.

Сонгодог бичгийн өмнөх дурсгалын хэлний онцлогийн талаар проф. Н.Поппе сонирхолтой өгүүлэл[44] нийтлүүлснээс гадна проф. М.Вайерсийн "Сонгодог бичгийн өмнөх монгол хэлний түүхэн хэл зүйн судалгаа"[45] хэмээх дорвитой бүтээл хэвлэгдсэн билээ. Проф. М.Вайерс уг номдоо сонгодог бичгийн өмнөх дурсгалын үсэг зүй, авиан зүй, хэл зүйн онцлогийг дундад үеийн монгол хэлний зарим дурсгалуудтай харьцуулан судалсан байдаг.

Сүүлийн үед сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгал буюу XIII-XIV зууны үеийн монгол бичгийн хэлийг судалсан хэд хэдэн бүтээл хэвлэгдэн гарсан нь уул сэдвийн судалгааг урагш нь ахиулсаар байна[46].

Сонгодог монгол бичгийн өмнөх дурсгалууд нь эртний монгол хэлний сүүл үеийн онцлог болон дундад үеийн монгол хэлний хэл зүй, үсэг зүй, үгийн сангийн байр байдлыг судлах үнэт хэрэглэгдэхүүн болоод зогсохгүй, тухайн үеийн монголын соёл, утга зохиол, түүх, угсаатны зүй, гадаад харилцаа зэрэг тал бүрийн асуудлыг шинжлэх чухал гэрч баримт болох тул өрнө, дорнын эрдэмтэн мэргэд олон жилийн турш анхааран судалсаар иржээ.

Энэ үеийн дурсгалыг Өрнөдийн эрдэмтэд XIX зууны эхэн үеэс судалж эхэлсэн билээ. Тухайлбал, одоогоор мэдэгдэж буй монгол бичгийн хамгийн анхны дурсгал болох "Чингисийн чулууны бичиг"-ийн тухай анхны мэдээг Оросын Сибирь судлаач Г.Спасский "Сибирский вестник" (Сибирийн мэдээ)

---

[40] Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменнего языка и халхасского наречия, Введение и фонетики, Л.,1929, XII+436 стр.

[41] Н.Н.Поппе, Грамматика письменно-монгольского языка, М-Л.,1937, 196сс.; N.Poppe, Grammar of Written Mongolia, Wiesbaden, 1954, 195 pp; Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, т.I, 1953, 240 сс. ; Г.Д.Санжеев, Старо-письменный монгольский язык, М.,1964, 89 сс.; Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, I-IV, УБ., 1964-1967.

[42] Ж.Надмид, Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм, УБ., 1967, 131 тал.

[43] Ц.Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, УБ., 1981, 168 тал; Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2002, 300 тал.

[44] N.Poppe, Bemerkungen zum vorklassischen Schriftmongolisch (Anlässlich des Buches von M. Weiers), ZAS, Bd, 3, 1969, 105-128.

[45] M.Weiers, Untersuchungen zu einer historischen Grammatik des präklassischen Schriftmongolisch, AF, Bd.28., Wiesbaden, 1969, 238ss.

[46] Qasbayan-a, Dumdadu jayun-u Mongol kelen-ü sudulul, ÖMSKKQ, 1996, 490 tala; Šongqor, Erten-ü mongyol kelen-ü sudulul, ÖMSKKQ, 1996, 806 tala; М.Н.Орловская, Язык монгольских текстов XIII-XIV веков, ИВ РАН, М.,1999, 182 стр.

сэтгүүлийн 1818 оны дугаарт нийтлүүлжээ[47]. Энэ нь Өрнөдийн хэвлэлд гарс уйгуржин монгол үсгийн талаарх хамгийн анхны мэдээ бололтой.

Францын дорно дахины судлаач Абел-Ремюза Ил хаан Аргун, Өлзи нараас Францын IV Гоо Филипп хаанд илгээсэн 1289, 1305 оны хоёр захидл Францын үндэсний архиваас олж, 1824 онд "Memoires sur les Relations politiqu des princes chretiens et particulierement des rois de France, avec les emprereu mongols. Second memoire. Relations diplomatiques des princes chretiens avec l rois de Perse la race de Tchinggis, depuis Houlagou, jusqu'au regne d'Abousa "Загалмайтны шашны хун тайж нар, тухайлбал Францын хаад Монголы хаадтай улс төрийн талаар харилцаж байсан тухай тэмдэглэл. Хоёр дах тэмдэглэл. Загалмайн шашны хун тайж нар, Хулагугаас Абу-Сайдын төр бари үе хүртэлх Перс дэх Чингисийн удмын хаадтай тогтоосон дипломат харилцаа" хэмээх өгүүлэл бичиж уг хоёр захидлын хэсэгчилсэн франц орчуулга, лати галиг, үгсийн тайлбарыг хэвлүүлэхийн хамт захидлуудын эхийг чулуун бараа хуулбарлан нийтлүүлжээ. Мөн энэ жил академич И.Я.Шмидт уг хоёр захидлы галиглан германаар орчуулан нийтэлсэн байна[49]. Шмидтийн энэ бүтээл Абел Ремюзагийн судалгааг урагш нь ахиулсан төдийгүй дараа дараагийн судлаачда үлгэр жишээ болжээ.

Академич И.Я.Шмидт мөн 1834 онд "Чингисийн чулууны бичиг"-ий судлаад "Bericht über einer Inschrift aus der altesten Zeit der Mongolenherrschaft ("Монголын ноёрхлын эхэн үеийн нэгэн бичээсийн тухай мэдээлэл") хэмээх өгүүлэл нийтлүүлсэн юм[50].

Ийнхүү Францын эрдэмтэн Абел-Ремюза, ялангуяа Өрнөдийн монгол судлалын үүд хаалгыг нээсэн их эрдэмтэн И.Я.Шмидт нар сонгодог монгол бичгийн өмнөх дурсгалыг нягтлан судлах үйлсийг эхэлжээ.

Францын хун тайж Р.Бонапарт 1895 онд Парист хэвлүүлсэн алдар Атластаа уул хоёр захидлыг гэрэл зургаар нийтлүүлсэн нь Абел-Ремюзагийн чулуун барын хуулбарын алдаа мадгийг илрүүлж, цаашид нарийвчлан судлахад их тустай ажил болсон юм[51].

Оросын монголч А.М.Позднеев 1896 онд нийтлүүлсэн "Лекции по истории монгольской литературы" ("Монголын уран зохиолын лекц") номынхоо тэргүүн дэвтэрт "Чингисийн чулууны бичиг", дээрхи хоёр захидал, Абдуллын пайз, Абканы бичээс зэрэг дурсгалыг судалсан байдаг[52].

Буриадын авьяаслаг эрдэмтэн Банзарын Дорж 1891 онд "Чингисийн чулууны бичиг"-ийн нэлээд нягт сайн судалгааг нийтлүүлсэн билээ[53].

---

[47] Г.И.Спасский, Древности Сибири, "Сибирский вестник", 1818. Часть IV. Отд II, 116-124.

[48] Abel-Rémusat, Mémoires sur les relations politiques des princes chrétiens et particullièrement des rois de France, avec les empereurs mongols. Second Mémoire. Relations diplomatiques des Princes chrétièns avec les rois de Perse de la race de Tchinggis, depuis Houlagou, jusqu'au règne d'Abousaïd. "Histoire et Mémoires de l'Institut Royal de France, Académie des Inscriptions et belles-lettres", t.YII. Paris,1824, 335-438.

[49] I.J.Schmidt, Philologisch-Kritische Zugabe zu den von Herrn Abel-Remusat bekannt gemachten, in den Königlich-französischen Archiven befindlichen, zwei mongolischen Original-Briefen der Könige von Persien Argun und Öldshäitu an Philipp den Schönen, St. Pbg.,1824.

[50] I.J.Schmidt, Bericht über eine Inschrift aus der ältesten Zeit der Mongolian-Herrshaft, Mém. de.l'Ac. de Sciences de St.Pbg. VI[e] serie, vol. II, 1834, 243-256.

[51] P.R.Bonaparte, Documents de l'époque mongole des XIII-e et XIV-e siècles, Paris, 1895, 15pl.

[52] А.М.Позднеев, Лекции по историй монгольской литературы, Т. I, 1896, 240 сс.

[53] Доржи Банзаров, Объяснение монгольской надписи на памятнике князя Исунке, племянника Чингис-хана, "Черная вера или шаманство монголов", Спб. 1891, 88-105; "Собрание сочинения", М., 1955, 186-206, reprint, 1997, 106-117.

XX зууны эхэн үеэс уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүдийг шинээр нээн олох, судлан нийтлэх үйлст Францын монголч П.Пеллио, Польшийн проф. В.Л.Котвич, Оросын И.Клюкин, С.А.Козин нар чухал хувь нэмэр оруулсан юм.

Тухайлбал, проф. П.Пеллио Гүюг хааны тамгын бичгийг анх судлан нийтлүүлснээс[54] гадна хэд хэдэн шинэ дурсгал нээн олж хэвлүүлжээ[55].

Проф. В.Л.Котвич Эрдэнэ-зуугийн бичээс, Дунхуангийн агуй дахь Төлөг Төгсийн бичээс зэргийг анх судалж, мөн Ил хаадын захидлыг олон талаас нь шинжилсэн цуврал өгүүлэл туурвисан байна[56].

Оросын судлаач И.Клюкин Ил хаадын хоёр захидлыг Абел-Ремюзагийн 1824 оны хуулбарыг үндэслэн судалж хоёр өгүүлэл нийтлүүлснээс [57] гадна "Чингисийн чулууны бичиг"-ийг судалсан өгүүлэл нь одоо ч үнэ цэнээ алдаагүй сайн бүтээл болжээ[58].

Академич С.А.Козин 1935 онд Аргун, Өлзийт нарын захидлыг шинжилсэн хоёр өгүүлэл нийтэлсэн байдаг[59].

Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалт бичгүүдийг судлах ажилд хамгийн их хувь нэмэр оруулсан, хамгийн олон бүтээл туурвисан хүн бол АНУ-ын нэрт монголч, проф.Ф.В.Кливез (1911-1995) билээ. Тэрбээр 1942 оны 5-р сард "1362 оны нангиад-монгол бичээс" бүтээлээрээ Харвардын их сургуульд гүн ухааны докторын зэрэг хамгаалж, уг ажлаа "Азийн судлалын Харвард сэтгүүл"-ийн 1949 оны 12-р ботид хэвлүүлснээс хойш [60] дэлхийн монгол судлалын ертөнцөд шүр сувд болсон бүтээлүүдээ бараг бүгдий нь энэ сэтгүүлд нийтлүүлсэн юм*.

---

[54] P.Pelliot, Les Mongols et la Papauté, "Revue de l'orient Chrétien", 3-e série, t. III (XXIII), №1 et 2, (1922-1923), Paris, 1923, 3-30.

[55] P.Pelliot, TP, t.XXV, 1927, 148; P.Pelliot, Neuf notes sur des questions d'Asie Centrale, TP, vol. XXVI, 1928, 219; P.Pelliot, Les document du Musée de Téhéran, "Athār-é-Irán; Annales du Service Archéologique de l'Iran I", Paris, 1936, 37-44, fig. 28-31.

[56] В.Котвич, Монгольские надписи в Эрдэни-Зу. "Сборник музея Антропологии и Этнографии имени Петра Великого при Российской Академий наук", V. 1918, 205-214; В.Л.Котвич, Поправки к разбору монгольских писем персидских иль-ханов, ЗКВ, том I, 1925, 342-344; В.Котвич, 13-р зууны эхэн үед монголчууд дэлхий нийтийн энх тайвангийн санааг сэдэж үүсгэсэн болох нь. (Ц.Шагдарсүрэн монголчлов), ХЗС, t. IX, 1972, 205-214; W. Kotwitz, Quelques données nouvelles sur les relations entre les Mongols et les Ouigours. RO, t.II, 1926, 240-247; W. Kotwitz, (Review in polish), I.Klukin, The most ancient mongolian inscription on the Kharkhira (Chingis Khan) stone, (Mémoires de l' Université d'État à l'Extrême-Orient. sér. YI:5), Vladivostok, 1927. RO, t. VII (1929-1930), 1931, 195-197; W. Kotwitz, En marge des lettres des il-khans de Perse, retrouvées par Abel Rémusat, CO №4, Lwow. 1933, Reprint; RO, t.XVI, (1950), 1953, 369-404; W.Kotwitz, Les Mongols, promoteurs de l'idée de paix universelle au début du XIII^{e} siècle, "La Pologne au VIIe Congrès International des Sciences Historiques" I. Warszawa, 1933, 199-204, Reprint; RO, t.XVI(1950) 1953, 428-434; W.Kotwicz, Quelques mots encore sur les lettres de il-khan de Perse retrouvées par Abel-Remusat, CO, № 10, Wilno 1936, 1-22, reédité; RO, t.XVI, 1953, 405-427.

[57] И.Клюкин, О чем писал Иль-хан Аргун Филиппу Красивому в 1289 году, Владивосток, 1925, VIII+IV+45; И.Клюкин, Письмо Улдзэйту Ильхана к Филиппу Красивому, Эдуарду 1-му и прочим крестоносцам, "Труды Гос. Дальневосточ. Ун-та ", Серия VI:2, Владивосток, 1926, 26 сс

[58] И.Клюкин, Древнейшая монгольская надпись на Хорхираском /"Чингисхановом"/ камне, "Труды Гос. Дальневосточ. Ун-Та", Серия, VI. №5, Владивосток, 1927, 38 сс.

[59] С.А.Козин, Язык первого периода истории монгольской литературы /По письмам персидских иль-ханов 1289-1305/, ИАН, отд. общ. наук, 1935, №5, 477-500; С.А.Козин, К вопросу о дешифровании дипломатических документов монгольских иль-ханов, ИАН, отд. общ. наук, 1935, №7, 645-655.

[60] F.W.Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1362 in Memory of Prince Hindu, HJAS, vol,12, №1-2, 1949, 1-133, pl.I-XXVII.

* Профессор Ф.В.Кливезийн бүтээлийн талаар "Ерөнхий номзүй"-ээс лавлана уу.

Арвин баялаг баримт хэрэглэгдэхүүнийг шавхан ашиглаж, эх бичгийг нягт нямбай судлан шинжилсний үндсэн дээр дүгнэлт нуталгаа гаргадгаараа проф. Ф.В.Кливезийн бүтээлүүд туйлын үнэ цэнэтэй төдийгүй арга зүйн хувьд ч үлгэр жишээ болохуйц байдаг онцлогтой.

Түүний нангиад-монгол бичээсийн олонх судалгааг авч үзвэл,

1. Preface (Өмнөх үг)
2. Notes to the Preface (Өмнөх үгийн зүүлт)
3. Introduction (Удиртгал)
4. Notes to the Introduction (Удиртгалын зүүлт)

Part I (Тэргүүн хэсэг)

5. Translation of the Chinese Text (Нангиад эхийн орчуулга)
6. Notes to the Tranlation of the Chinese Text (Нангиад эхийн орчуулгын зүүлт)
7. Chinese Text (Нангиад эхийн гэрэл зураг)

Part II (Дэд хэсэг)

8. Transcription of the Mongolian Text (Монгол эхийн галиг)
9. Index Verborum Mongolicorum (Монгол эхийн үгийн цэс)
10. Translation of the Mongolian Text (Монгол эхийн орчуулга)
11. Notes to the Translation of the Mongolian Text (Монгол эхийн орчуулгын зүүлт)
12. Mongolian Text (Монгол эхийн гэрэл зураг) гэсэн тогтсон загвар, дэс дараатай байдаг.

Мөн проф. Ф.В.Кливез, Бельгийн нэрт монголч А.Мостэрттэй хамтран Ил хаадын таван захидлыг судалж хоёр сайн бүтээл гаргажээ[61].

Нангиад-монгол хэлээр байгаа бүхий л дурсгалыг судлахад Ф.В.Кливезийн монгол, нангиад хэл бичгийн тэгш мэдлэг нь илрэн гарч энэ салбар дахь хамгийн шилдэг монгол судлаач гэдгээ аль хэдийн харуулсан билээ. Тэрбээр ийнхүү том том дурсгалыг шинжлэхээс гадна уг дурсгалууд дахь зарим нэг үг хэллэгийн утга учрыг тайлбарласан хэд хэдэн товч өгүүлэл нийтлүүлсэн юм[62].

---

[61] A.Mostaert, F.W.Cleaves, Trois Documents Mongols des Archives Secrètes Vaticanes, HJAS, vol, 15, № 3-4, 1952, 419-506; A.Mostaert, F.W.Cleaves, Les letters de 1289 et 1305 des Ilkhan Aryun et Öljeitü à Philippe le Bell, "Scripta Mongolica, Monographie Series I", Harvard-Yenching Institute. Cambridge Mass, 1962, 104 pp, pl.I-XII.

[62] F.W.Cleaves, The Expression *dur-a qočarulčaju* in the Letter of Öljeitü to Philippe le Bel. HJAS, vol.11, № 3-4, 1948, 441-445; F.W.Cleaves, A Chancellary Practice of the Mongols in the Thirteenth and Fourtheenth Centuries. HJAS, vol.14, № 3-4, 1951, 495-526; F. W. Cleaves, A Medical Practice of the Mongols in the Thirteenth and Fourteenth Century, HJAS, vol. 17, № 3-4, 1954, 428-444; F.W.Cleaves, tomuγ-a / t'o-mu-hua, HJAS, vol.17, № 3-4, 1954, 445-452; F.W.Cleaves, Aldar Čab-Čab Aldar, HJAS, vol.18, № 1-2, 1955, 221-233; F.W.Cleaves, Saqid-Zāh(i)d, HJAS, vol.18, № 1-2, 1955, 234-238;

Проф. Ф.В.Кливез амьдралынхаа сүүлийн жилүүдэд "Ачлалт ном"-ын монгол орчуулгыг судалсан цуврал өгүүлэл хэвлүүлж байв**. Ийнхүү проф. Фрэнсиз Вүүдмэн Кливез бол сонгодог монгол бичгийн өмнөх дурсгалын судлалаар XX зуунд бусдаасаа хол тасарсан гайхамшигт эрдэмтэн байлаа.

А.ф. Ле Кохоор удирдуулсан Германы шинжилгээний анги XX зууны эхээр Хятадын Шинжаан мужийн Турфан нутгаас эртний олон зүйлийн хэл, бичгээр туурвисан баялаг ном судар олж аваачсан билээ. Үүний доторхи монгол дурсгалыг судлахад Финийн алдарт монголч Г.И.Рамстедт эң тэргүүнд анхаарлаа хандуулж Берлин дэх Турфаны цуглуулгын доторхи хэдэн захидал бичгийг судлаад 1909 онд "Mongolische Briefe aus Idiqut-Schäri bei Turfan" ("Турфаны Идихут-Шэрийн монгол захидлууд") хэмээх өгүүлэл нийтлүүлжээ[63]. Үүнээс хойш уул дурсгалыг хэн ч сонирхон судлалгүй байсаар бараг хагас зууны дараа буюу 1954 онд гурван тивийн, гурван улсын, гурван нэрт эрдэмтэн тухайлбал, Монголын академич Ц.Дамдинсүрэн[64], Германы монголч Э.Хэниш[65], АНУ-ын проф. Ф.В.Кливез[66] нар тус тустаа бүтээл хэвлүүлжээ.

Ялангуяа Чойжи-Одсэрийн 1312 оны Бодичария-авадарагийн орчуулга, тайлбарын модон барын сүүлийн арваад хуудсыг шинжлэн судалсан Ф.В.Кливез, Э.Хэниш нарын судалгаа тун чухал бүтээлүүд болсон байна.

АНУ-ын алдарт монголч Н.Поппе Турфаны монгол цуглуулгын доторх нэгэн зохиолыг Македоны Александр хааны тухай бүтээл болохы нь олж тогтоон 1957 онд судлан хэвлүүлсэн юм[67].

Мөн тэрбээр "Алтан ордны үйсэн дээрх бичиг"-ийг анх тайлан уншиж ганц сэдэвт бүтээл[68] нийтлүүлснээс гадна 1926 онд Эрдэнэ-зуугийн монгол бичээс[69], 1960 онд Турфаны цуглуулга дахь нэгэн монгол шүлэг[70], 1961 онд Мөнх хааны гэрэлт хөшөөний бичгийг[71] тус тус судлан хэвлүүлсэн бөгөөд 1962 онд нийтлүүлсэн "Antworten auf Professor Wellers Fragen" ("Профессор Веллерийн асуултанд хариулах нь")[72] хэмээх өгүүлэлдээ 1312 оны Бодичарияавадарагийн монгол орчуулгын талаар өгүүлсэн байдаг.

Проф. Э.Хэниш Берлин дэх Турфаны монгол цуглуулгын бараг бүх дурсгалыг эмхитгэн 1959 онд "Mongolica der Berliner Turfan-Sammlung. II. Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile" ("Берлин дэх Турфаны монгол цуглуулга. Берлин дэх Турфаны цуглуулгын монгол

** Профессор Ф.В.Кливезийн "Ачлалт ном"-ын судалгааны бүтээлүүдийн талаар "Ерөнхий номзүй"-ээс лавлана уу.

[63] G.J.Ramstedt, Mongolische Briefe aus Idiqut-Schäri bei Turfan, "Sitzungsberichte d.Preuss. Ak.d. Wiss", t.XXXII, 1909, 838-848.

[64] Ц.Дамдинсүрэн, Ардчилсан Герман Улсын Шинжлэх Ухааны Академиар орсон тухай тэмдэглэл, ШУ, 1954, №3, 22-29.

[65] E.Haenisch, Mongolica der Berliner Turfan-Sammlung. I. Ein buddhistisches Druckfragment vom Jahr 1312, ADAW, 1954, 1-22, pl. I-XXV.

[66] F.W.Cleaves, The Bodistw-a Čari-a Awatar-un tayilbur of 1312 by Čosgi Odsir, HJAS, vol.17, № 1-2, 1954, 1-129, pl. I-XXIV.

[67] N.Poppe, Eine mongolische Fassung der Alexandersage, ZDMG, 1957, Bd. 107, 105-129.

[68] Н.Н. Поппе, Золотоордынская рукопись на бересте, Труды Института Востоковедения, т. XXXVII, М-Л., 1941, 59+24 таб., Reprint; "Mongolica ", Wiesbaden, 1972.

[69] Н.Поппе, Предварительный отчет лингвистической экспедиции в Северную Монголию за 1926 год, (Отчет о поездке на Орхон летом 1926 года), Л., 1929, 1-25.

[70] N.Poppe, Ein mongolisches Gedicht aus den Turfan-Funden, GAJ, vol. V, 1960, 257-294.

[71] N.Poppe, Notes on the Monument in Honour of Mönke Khan, CAJ, vol.VI, 1961, 14-18.

[72] N.Poppe, Antworten auf Professor Wellers Fragen, CAJ, vol.VII, 1962, 42-59.

бичвэрүүдийн гэрэл зургийн хуулбар")[73] хэмээх ном хэвлүүлсэн нь цаашид нягтлан судлах боломжийг дэлхийн монголч нарт бүрдүүлж өгсөн буянтай үйлс болжээ.

Судлаачид хожим нь Э.Хэнишийн номд ороогүй хэд хэдэн ном судрын тасархайг шинээр нийтлүүлсэн билээ[74].

Мажарын нэрт монголч Л.Лигети (1902-1987) академич бээр сонгодог бичгийн өмнөх дурсгалыг судалж хэд хэдэн өгүүлэл*** нийтлүүлснээс гадна XIII-XIV зууны үеийн уйгуржин монгол бичгийн бараг бүх дурсгалыг эмхитгэн шинжилгээний нягт сайн галиг, товч тайлбар, ном зүйн хамт 1963 онд мажар[75], 1972 онд франц[76] хэлээр хэвлүүлж, мөн уг номд орсон бүх дурсгалын үгийн цэсийг[77] нийтэлсэн нь нэн тустай ажил болжээ.

Германы нангиадч, монголч Х.Франке профессор хэд хэдэн шинэ дурсгал нийтлүүлсэн юм*.

Австралийн монголч, проф. И.де Рахевильц 1969 онд "Мухаммед багшийн шүлэг" [78] -ийг судлан хэвлүүлснээс хойш, "Чингисийн чулууны бичиг"[79], "Төрэгэнэ хатны зарлиг"[80], "Гүюг хааны тамгын бичиг"[81], "Ачлалт ном"[82] зэрэг сонгодог бичгийн өмнөх дурсгалуудыг дахин нягтлан судалсан нь ихээхэн чухал зүйл болжээ.

1970 онд Германы эрдэмтэн Г.Херрман Ираны Ардабил хотоос перс-монгол хоёр хэлээр бичсэн Ил хаадын зарлиг болон уйгуржин монгол үсгийн хэсэг бусаг дурсгал бичгүүд олсныг 1975 онд Г.Дёрфер, Г.Херрманн нар хэвлэн

---

[73] E.Haenisch, Mongolica der Berliner Turfan-Sammlung. II. Mongolische Texte der Berliner Turfan-Sammlung in Faksimile, ADAW, 1959, 59 pp.

[74] Д.Цэрэнсодном, Турфаны цуглуулгын Т II,607 /Ерөөлийн хаан хэмээх судрын шинээр олдсон тасархай/, SM, t.III (11), 1976, 221-227; G.Kara, Un fragment mongol de Tourfan, AOH, t. XXIV, f. 2, 1971, 165-171; G.Kara, Weitere mittelmongolische Bruchstücke aus der Berliner Turfansammlung, "Altorientalische Forschungen", Bd.VI, Berlin, 1979, 181-203, pl.I-VII; L.Ligeti, Fragments mongols de Berlin, AOH, t.XXIV, f.2, Budapest, 1971, 139-164; D. Cerensodnom, M. Taube, Mongolica der Berliner Turfan-Sammlung, 1993, 230+57 pl.

*** Профессор Л.Лигетийн бүтээлийн талаар "Ерөнхий номзүй"-ээс лавлана уу.

[75] L.Ligeti, Preklasszikus emlékek I. MN.1, Budapest. 1963, 176 pp.

[76] L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, 296 pp.

[77] L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, I, Budapest, 1970, 169 pp; L.Ligeti, Monuments préclassliques, 1.(XIIIe et XIVe siècles), Deuxième partie. IVLMMT, II, Budapest, 1972, 382pp.

* Профессор Х.Франкегийн бүтээлүүдийг "Ерөнхий номзүй"-ээс лавлана уу.

[78] I.de Rachewiltz, The Mongolian Poem of Muḥammad al-Samarqandī, CAJ, vol. XII, 1969, 280-285.

[79] I. de Rachewiltz, Some Remarks on the Stele of Yisüngge, "Tractata Altaica, Denis Sinor Sexagenario Optima de Rebus Altaicis Merito Dedicata ", Redigerunt Walther Heissig, John R. Krueger, Felix J. Oinas, Edmond Schütz, Wiesbaden, 1976, (XI+775 pp), 487-508.

[80] I.de Rachewiltz, Some Remarks on Töregene's Edict of 1240, PFEH, vol.23, (March, 1981), 39-63, 1pl; I. de Rachewiltz, Was Töregene Qatun Ögödei's 'Sixth Empress' ?, "ОУМЭ-ий VIII их хурал", "Mongolica. An International Annual of Mongol Studies", vol.10(31), 2000, 441-460.

[81] I. de Rachewiltz, Qan, Qa'an and the Seal of Güyüg, "Documenta Barbarorum, Festschrift für Walther Heissig zum 70. Geburtstag", Hrsg. von Klaus Sagaster und Michael Weiers. Veröftentlichungen der Societas Uralo-Altaica, Band 18, 37, 1983, 272-281.

[82] Der Blockdruck des Xiàojīng aus dem Palastmuseum in chinesisher und mongolischer Sprache, ZAS, Bd 12, 1978, 152-235; I. de Rachewiltz, The Preclassical Mongolian Version of the Hsiao-ching, ZAS, Bd.16, 1982, 7-109; I. de Rachewiltz, More about the Preclassical Mongolian Version of the Hsiao-ching, JAS, Bd.19,1986, [27]-37.

гаргасан нь сонгодог бичгийн өмнөх дурсгалын судлалд чухал хувь нэмэр хандив болсон юм[83].

БНХАУ-ын Хэнань (河南) мужийн Дэнфэн (登封县) сианы Шао-лин (少林) сүмийг 1972-1982 онд сэргээн засварлах үеэр газрын гүнд булагдсан 4 гэрэлт хөшөө илрүүлсэн байна. Эдгээр хөшөөний нэг нь 1314 онд сийлсэн гэрэлт хөшөө байжээ. Уул хөшөөний нэг талд уйгуржин монгол бичгийн гурав (1253 оны Мөнх хааны зарлиг, 1261 оны Хубилай хааны зарлиг, 1268 оны Хубилай хааны зарлиг), дөрвөлжин үсгийн нэг (1312 оны Буянт хааны зарлиг), нөгөө талд нангиад бичээс сийлсэн байна.

1991 оны 1-2 сард Японы судлаач Ж.Накамура, Т.Мацукава нар Шао-лин хийдэд очиж уул гэрэлт хөшөөний бичээсийг нягтлан судлаад Японы "Дотоод Азийн хэлний судлал" сэтгүүлийн 1993 оны YIII ботид "Шинээр илрүүлсэн монгол нангиад хавсарсан Шао-лин хийдийн зарлигийн хөшөө" хэмээх өгүүлэл нийтлүүлжээ. Тэд уул өгүүлэлдээ уйгуржин монгол үсгийн 3, дөрвөлжин үсгийн 1 зарлигийн бичээсийн латин галиг, япон орчуулга, тайлбар судалгаа, эхийн гэрэл зураг сэлтийг хэвлүүлсэн байна[84].

Өвөр Монголын эрдэмтэн Дов, Зуунаст нар уул хөшөөний бичээсийг очиж судлаад "Үндэсний хэл бичиг" сэтгүүлийн 1993 оны 5,6, 1994 оны 1-рт "Хэнань мужийн Дэнфэн сианы Шао-лин хийдээс малтан гаргасан уйгуржин монгол ба пагвагийн үсгийн зарлигийн хөшөөний тайлбар судалгаа" хэмээх өгүүлэл хэвлүүлсэн билээ. Уул цуврал өгүүлэлд Шао-лин хийдийн гэрэлт хөшөөний 4 зарлигийн бичээсийн латин галиг, нангиад орчуулга, үгсийн тайлбар судалгаа, эхийн гэрэл зураг зэргийг хэвлүүлсэн байна[85].

Өвөр Монголын судлаачид уйгуржин монгол үсгийн дурсгалыг нэлээд хожуу тухайлбал, 1980-аад оны эхэн үеэс судалж эхлээд сүүлийн үед тун эрч, далайцтай шинжилж байна. Тухайлбал 1983 онд эрдэмтэн Довын хэвлүүлсэн "Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичгүүд" [86] хэмээх ном онцгой ач холбогдолтой юм. Зохиогч уг бүтээлдээ "Чингисийн чулууны бичиг" тэргүүтнээс эхлээд "Мин улсын үеийн зарлиг ба айлтгал бичгүүд" хүртэлх XIII-XIV зууны үеийн 22 дурсгал бичгийг товч тайлбар, эхийн гэрэл зураг, уг эхийг дуурайсан хуулбар, одоогийн монгол бичгийн хөрвүүлэг, зарим үгсийн тайлбар сэлтийг багтаан хэвлүүлсэн нь сурах оюутан, судлах мэргэдэд тустай сайн бүтээл болжээ.

Профессор Зуунаст, Сэцэнцогт нар 1989 онд "Сайн үгт Эрдэнийн сан нэрт шастир" нэрээр Эрдэнийн сан Субашидын хамгийн анхны монгол орчуулга буюу Соном Гарагийн орчуулгыг бүх талаас нь судлан шинжилж, тайлбар судалгааны хамт хэвлүүлсэн билээ[87].

---

[83] G.Doerfer, Mongolica aus Ardabil, ZAS, Bd.9, 1975, 187-263; G.Herrmann, G.Doerfer, Ein persisch-mongolischer Erlass des Čalāyeriden Šeyh Oveys, CAJ, 1975, vol. XIX, 1-84; G.Herrmann, G.Doerfer, Ein persisch-mongolischer Erlaß aus dem Jahr 725/1325, ZDMG, Bd. 125,1975, 317-346.

[84] 中村淳, 松川節, 新発見の蒙漢合璧少林寺聖旨碑, "内陸アジア言語の研究", 1993, YIII, 1-92, +8pl.

[85]道布, 照那斯图, 河南登封少林寺出土的回鹘式蒙古文和八思巴字圣旨碑考释, "民族语文", 1993, № 5,1-3, № 6,59-71+2pl,1994, № 1,32-40+2pl.

[86] Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, 695 tal-a.

[87] Jaγunasutu, Sečenčoγtu, Sayin ügetü erdeni-yin sang neretü šastir, (Tulγur bičig-ün čuburul), ÖMAKQ, 1989, 859 tal-a.

Өвөр Монголын судлаач Д.Тулгуур 1362 оны Индү вангийн гэрэлт хөшөөний бичгийг судалж эрдмийн зэрэг хамгаалсан бөгөөд уул бүтээлээ 1992 онд "Индү вангийн хөшөөний монгол бичгийн судлал"[88] нэрээр тусгай ном болгон гаргажээ. Зохиогч уул бүтээлдээ уг дурсгалыг хэл шинжлэлийн үүднээс задлан шинжилсэн байдаг.

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Их зуу аймгийн нутагт орших Аржайн агуйн хананд Бурханы магтаал, Дар-Эхийн магтаал, Архадын магтаал зэрэг XV зууны сүүлч XVI зууны эхэн үед хамаарах 50 гаруй бичээс олдсоныг 1980-аад оны эхэн үеэс Өвөр Монголын эрдэмтэд нягтлан судалж, 1997 онд "Аржай агуйн уйгуржин монгол бичээсийн судлал" хэмээх ном гаргасан нь сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалын судлалд цоо шинэ нэмэр хандив болсныг тэмдэглэе[89].

БНХАУ-ын Шаньси (陕西) мужийн Ху сиан (户县)-ы төв Гуань (关) хотоос баруун зүгт 10 км-т орших Чун Ян-гун (重阳宫) хэмээх бомбын сүмд Юань улсын үеийн монгол-нангиад үсгээр бичсэн Жибинтөмөр вангийн гэрэлт хөшөө хадгалагдаж байдаг байна. Уул хөшөөний магнайн бичээс нь дөрвөлжин үсгээр нангиад хэлээр бичигдсэн бөгөөд дээд талд нь уйгуржин монгол, доод талд нь нангиад бичээс тус тус сийлжээ. Уйгуржин бичээс нь 1277 оны Жибинтөмөр вангийн зарлигийн бичээс болно.

Энэхүү гэрэлт хөшөөний бичээсийг БНХАУ-ын эрдэмтэн Дов, Зуунаст, Лиу Жаохе нар судалж "Үндэсний хэл бичиг" сэтгүүлийн 1998 оны 2-рт "Уйгуржин монгол үсгийн Жибинтөмөр вангийн зарлигийн бичээсийн тайлбар судалгаа" хэмээх өгүүлэл нийтлүүлсэн билээ[90].

Зохиогчид уул өгүүлэлдээ уйгуржин монгол бичээсийн латин галиг, уйгуржин монгол сийрүүлэг, хятад бичээс, уйгуржин бичээсийн хятад орчуулга, тайлбар судалгаа, эхийн гэрэл зураг сэлтийг нийтлүүлсэн байна.

Дов нарын энэхүү судалгаа нь сонгодог монгол бичгийн өмнөх үеийн нэгэн шинэ дурсгалыг судалгаа шинжилгээний эргэлтэнд оруулснаараа чухаг ач холбогдолтой юм.

Манай орны судлаачид сонгодог бичгийн өмнөх дурсгалыг судлах ажилд 1950-иад оноос хувь нэмэр оруулж эхэлжээ. Үүнд, Монгол улсын нутаг дэвсгэрт хадгалагдаж байгаа цөөн дурсгалын нэг болох 1257 оны "Мөнх хааны гэрэлт хөшөө"-г Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутгаас О.Намнандорж 1953 онд нээн олж, 1956 онд тусгай товхимол[91] хэвлүүлсэн нь уйгуржин монгол бичгийн судлалд нээлт болсон төдийгүй, энэ чиглэлийн судалгааны үндэс суурийг эх орондоо тавьсан гавьяат үйл болжээ.

Мөн уг дурсгалыг судалж академич Ц.Дамдинсүрэн 1957 онд, академич Б.Ринчен 1958 онд, Ш.Ёнхор 1962 онд тус тус өгүүлэл хэвлүүлэв[92].

---

[88] Tulγaγuri, "Intü ong-un kösiy-e"-yin mongγol bičig-ün sudulul, ÖMSKKQ, 1992, 443 tal-a.

[89] Qaserdeni, Danzan, Bürinbatu, Гarudi, Jalsan, Batujirγal, Engkebaγatur, Arjai aγui-yin uyiγurjin mongγol bičigesü-yin sudulul, "Liyooning-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a", 1997, 7+54+36+387 tal-a.

[90] 道布, 照那斯图, 刘兆鹤, 回鹘式蒙古文只必帖木儿大王令旨释读, "民族语文",1998, №2, 9-17+2pl.

[91] О.Намнандорж, Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай, УБ, 1956, 28 тал

[92] Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм, УБ., 1957, 35-36; 1999, 53-54; Rinčen L'inscription sinomongole de la Stèle en l'honneur de Möngke qaγan, CAJ, IV, 1958, 130-143, fig.6 Ш.Ёнхор, Мөнх хааны гэрэлт хөшөөний монгол бичгийг дахин уншсан нь, "УИС-ийн манж-монгол хэлний ангийн оюутнуудын эрдэм шинжилгээний бичиг", УБ., 1962(63), 59-67.

Академич Ц.Дамдинсүрэн 1957 онд хэвлүүлсэн "Монголын уран зохиолын тойм" номдоо Чингисийн чулууны бичиг, Гүюг хааны тамгын бичиг, Мөнх хааны гэрэлт хөшөөний бичиг, Өлзийт султаны бичиг зэргийг оруулсан байдаг[93]. Мөн тэрбээр, 1959 онд нийтлүүлсэн "Монголын уран зохиолын дээж зуун билиг оршивой"[94] хэмээх алдарт бүтээлдээ "Алтан ордны үйсэн дээрх бичиг", "Сулхарнайн тууж", "Бодичариявадарагийн аравдугаар бүлгийн тайлбар" зэргийг орчин үеийн монгол үсгээр сийрүүлж, товч тайлбартайгаар хэвлүүлснээс гадна, Чойжи-Одсэрийн тухай[95], Сулхарнайн туужийн тухай[96] өгүүлэл тус тус нийтлүүлсэн нь буй.

Академич Б.Ширэндэв Ил хаан Аргуны 1289 оны захидлын гэрэл зураг, мөн захидлын болон 1305 оны Өлзийт султаны захидлын хөрвүүлэг зэргийг 1968 онд нийтлүүлжээ[97].

Академич Д.Цэрэнсодном 1960-аад оноос эхлэн Ч.Алтангэрэлийн хамт болон дангаараа Турфаны монгол дурсгалын талаар, түүнчлэн уг дурсгалын доторх тасархай хуудсуудыг ямар номын хэсэг болохыг нь тодруулсан олон цуврал өгүүлэл нийтлүүлсэн билээ**. Турфаны дурсгалыг олон жил судалсны дүнд тэрбээр, Германы монголч, доктор М.Таубетэй хамтран 1993 онд "Die Mongolica der Berliner Turfan-Sammlung" ("Берлин дэх Турфаны цуглуулгын монгол дурсгал")[98] хэмээх ном хэвлүүлсэн билээ. Уг бүтээл Турфаны монгол дурсгалуудын латин галиг, герман орчуулга, тайлбар судалгаа, бүх үгийн толь, зарим эхийн гэрэл зураг зэргийг багтаасан бүрэн нэгтгэл зохиол болсон байна.

Мөн "Чингисийн чулууны бичиг"-ийн судлалаар Х.Пэрлээ, Д.Жамсранжав[99], 1312 оны Бодичариявадарагийн орчуулга, тайлбарын тухай Д.Төмөртогоо[100], "Алтан ордны үйсэн дээрх бичиг"-ийн талаар Д.Цэнд[101], 1305 оны Өлзийт султаны захидлын тухай Ц.Сүхбаатар[102] нар тус тус өгүүлэл бичсэн байна.

Эрдэмтэн Х.Лувсанбалдан Бээжингийн хааны ордны музейд хадгалагдаж байсан "Ачлалт ном"-ын нангиад-монгол эхийг олж аваад латин галиг, үгийн цэс, тайлбар судалгаа, эхийн гэрэл зураг сэлтийн хамт "Ачлалт номын тухай"[103]

---

[93] Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм, УБ., 1957, (158 tal-a), 34-41, 88-91, 102-119.

[94] Če.Damdinsürüng, Mongγol-un uran jokiyal-un degeji jaγun bilig orusibai, CSM, t. XIV, UB.,1959, (599 tal-a), 28-29, 136-146, 146-152, 152-154, 154-158, 160-162, 162-166, 166-170, 170-173.

[95] Ц.Дамдинсүрэн, 14-р зууны үеийн хэл бичгийн эрдэмтэн Чойжи-Одсэр, "Шинжлэх ухааны хүрээлэнгийн бүтээл", УБ., 1957, № 2, 65-76.

[96] Č.Damdinsürüng, Sulqarnai-yin tuγuji-yin tuqai, MKJT, 1959, № 8, 43-54.

[97] Б.Ширэндэв, Эртний монгол бичгийн хуулбар ингэж манайд шилжин ирэв, ШУАМ, 1968, №2, 39-53; Б.Ширендыб, Фотокопии с оригиналов дипломатических послании, В кн: "Б.Ширендыб, Избранные произведения", М., 1973, 88-92.

** Академич Д.Цэрэнсодном, судлаач Ч.Алтангэрэл нарын бүтээлийн талаар "Ерөнхий номзүй"-ээс лавлана уу.

[98] D.Cerensodnom, M.Taube, Die Mongolica der Berliner Turfan-Sammlung, Berlin, 1993, 230+57 pl.

[99] Х.Пэрлээ, Гурван өгүүлэл, SM, t.III, f. 13-15, УБ., 1962, (48 тал) 3-23; Д.Жамсранжав, "Буха сужигай" гэдэг нэрийн учир, "ОУМЭ-ий IV их хурал", I боть, УБ., 1985 (84), 455-458.

[100] Д.Төмөртогоо, 1312 оны Bodicaryavatara – yin tayilburi, ХЗ, t.IV, УБ., 1968, 173-180; Д.Төмөртогоо, Bodicaryavatara-ийн монгол орчуулгууд, МС, T.VI, f.22-33, УБ., 1968(1969), 151-160.

[101] Д.Цэнд, "Алтан ордны үйсэн дээрх бичиг" хэмээх зохиолын судлалд, SM, t.III (11), УБ., 1976, 238-259.

[102] Ts. Sukhbaatar, Re-reading the note from Ulziit sultan, "ОУМЭ-ийн VI их хурал, Илтгэлүүдийн товчлол", УБ., 1992, 102-103.

[103] Х.Лувсанбалдан, Ачлалт номын тухай, SM, t. III, f. 12, УБ., 1961, 149+1в-38а.

хэмээх бүтээлийг 1961 онд гаргажээ. Мөн тэрбээр, 1340 оны Аруг вангийн гэрэлт хөшөөний бичээсийг судлан 1962 онд нийтлүүлсэн юм[104].

Х.Лувсанбалданы энэхүү хоёр бүтээл нь түүнээс өмнө дэлхийн монгол судлалд хэн ч судлаагүй зүйлийг барьж авснаараа ихээхэн ач холбогдолтой юм. Х.Лувсанбалданы судалгаа гарсны дараагаар л дээрх хоёр дурсгалыг судалсан Ф.В.Кливез, Д.Кара, Л.Лигети, И.де Рахевильц [105] зэрэг гадаадын нэрт монголчдын бүтээл дараа дараагаар хэвлэгдсэн билээ.

Судлаач Д.Жамсранжав 2003 онд хэвлүүлсэн "Чулуун ном"[106] хэмээх бүтээлдээ 1224/25 оны "Чингисийн чулууны бичээс" (13-26, 89-р тал), 1240 оны "Өгэдэй хааны зарлигийн хөшөөний бичээс"(27-46, 90-р тал), 1246 оны "Гүюг хааны тамгын бичиг" (47-58, 91-95-р тал), 1257 оны "Мөнх хааны хөшөөний дээрхи монгол бичээс" (59-72, 96-100-р тал) зэрэг сонгодог монгол бичгийн өмнөх дөрвөн дурсгалын тайлбар судалгаа, гэрэл зураг сэлтийг нийтлүүлжээ.

Академич Д.Төмөртогоо сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалуудыг эмхитгэн латинаар галиглаж үгийн цэс үйлдсэн томоохон бүтээл болох "Монгол бичигийн дурасхалын судалгаа" номоо Тайвань улсад хэвлүүлж байгаа билээ. Энэ бүтээл нь сонгодог монгол бичгийн өмнөх дурсгалын судалгаанд томоохон хувь нэмэр оруулах нь эргэлзээгүй.

3. Сонгодог монгол бичгийн өмнөх үеийн дурсгалын жагсаалт, судалгааны номзүй

Сонгодог бичгийн өмнөх үеийн дурсгалт бичгүүдийн бүртгэл жагсаалтыг Б.Я.Владимирцов [107], Б.Ринчен [108], Д.Цэнд [109], Ж.Надмид [110], М.Вайерс [111], Л.Лигети[112], Ө.Мандах[113], Д.Төмөртогоо[114] нар удаа дараа нийтлүүлсэн билээ.

Бид энд сонгодог бичгийн өмнөх дурсгалуудын харьцангуй бүрэн бүртгэл хийгээд судалгааны бүтээлийн номзүйг хэвлүүлж байна. Ийн

---

[104] Х.Лувсанбалдан, Аруг вангийн хөшөөний бичиг, "Дандины "Зохист аялгууны толь" ба түүний тайлбарын тухай товч мэдээ ", SM, t. IV, f.6, УБ., 1962, 123-136, 1 зурагтай.

[105] 1340 оны "Аруг вангийн гэрэлт хөшөөний бичээс"-ийн талаар; L.Ligeti, Preklasszikus emlékek I. MN.1, Budapest. 1963, (176 pp), 67-69; L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 59-61; G.Kara, L'Inscription mongole d'Aruγ, prince de Yunnan, AOH, t. XVII, f.2, 1964, 145-173; F.W.Cleaves, The Lingji of Aruγ of 1340, HJAS, vol. 25, (1964-65), 1965, 31-78; "Ачлалт ном"-ын талаар; L.Ligeti, Preklasszikus emlékek I. MN.1, Budapest. 1963, (176pp), 9-37; L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, 76-104; Der Blockdruck des Xiàojīng aus dem Palastmuseum in chinesisher und mongolischer Sprache, ZAS, Bd 12, 1978, 152-235; I. de Rachewiltz, The Preclassical Mongolian Version of the Hsiao-ching, ZAS, Bd.16, 1982, 7-109; I. de Rachewiltz, More about the Preclassical Mongolian Version of the Hsiao-ching, JAS, Bd.19,1986, [27]-37; Профессор Ф.В.Кливезийн "Ачлалт ном"-ын судалгааны бүтээлүүдийн талаар "Ерөнхий номзүй"-ээс лавлана уу.

[106] Д.Жамсранжав, Чулуун ном, №1, УБ.,2003, 109 тал.

[107] Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменнего языка и халхасского наречия, Введение и фонетики, Л.,1929, (XII+436 стр.), 34-37.

[108] Б.Ринчен, Монгол бичгийн хэлний зүй, Тэргүүн дэвтэр, Удиртгал, УБ., 1964, 213-216.

[109] Д.Цэнд, XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалаас, ХЗ, t.II, УБ.,1964, 3-52.

[110] Ж.Надмид, Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм, УБ., 1967, 21-23, 47-50.

[111] M.Weiers, Untersuchungen zu einer historischen Grammatik des präklassischen Schriftmongolisch, AF, Bd.28., Wiesbaden, 1969, (238 ss.) 203-224.

[112] L.Ligeti, L.Ligeti, Preklasszikus emlékek I. MN.I, Budapest. 1963, 176pp. L.Ligeti, Monuments Préclassiques I, XIIIe et XIVe siècles, MLMC, III, Budapest, 1972, 296 pp.

[113] Ö.Manduqu, Tarudi, Yuan Čou, Dumdadu erten-ü mongγol kele, 1997, (702 tal-a), 6-22.

[114] Д.Төмөртогоо, Монгол хэлний түүхэн хэл зүй, Нэгдүгээр дэвтэр, Монгол хэлний түүхэн авиа зүй, УБ., 1992, (219 тал), 208-210; Д.Төмөртогоо, Монгол бичигийн хэл, "Монгол хэл шинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал), 301-311.

нийтлүүлэхдээ академич Л.Лигетийн 1972 оны бүтээлдээ хэрэглэсэн дэс дараа болон ангиллыг ерөнхийд нь баримтлахын хамт үүнээс хойш шинээр нээгдсэн, уг номд ороогүй дурсгалын бүртгэлийг олж мэдсэнийхээ хирээр нөхөн орууллаа.

А. Монгол

I. 1. Чингисийн чулууны бичиг (1224/1225)

Нийт 5 мөр, 21 үг бүхий энэ бичээсийг Сартуул иргэнийг байлдан дагуулсан аян дайнаас эх нутагтаа буцах замд Хамаг монгол улсын ноёдын их хуралдайн үеэр Чингисийн ач, Хасарын хүү Есүнхэ мэргэн 335 алд газарт бай харваж мэргэн онож дээд амжилт тогтоосны алдар гавьяаг дуурсган хөшөө босгожээ. Энэхүү дурсгал Эргүнэ мөрний нэгэн салаа болох Хархираа голын орчмоос анх олдсон бөгөөд эдүгээ Санкт Петербург хотын Эрмитаж музейд хадгалагдаж байна.

Уул хөшөөний дуураймал хуулбар Үндэсний түүхийн музейн өмнөх талбайд буй.

1. П.Аюушжав, "Чингисийн чулууны бичиг"-ийн үгийн санг алтай судлалын хүрээнд авч үзэх нь, "Altaica", t. III, УБ., 2004, 125-131.
2. Д. Банзаров, Объяснение монгольской надписи на памятнике князя Исунке, племянника Чингис-хана, "Черная вера или шаманство монголов", Спб. 1891, 88-105 "Собрание сочинения", М., 1955, 186-206, reprint, 1997, 106-117.
3. Ш.Бира, Чингисийн чулууны бичээсийн тухайд, "Монголын судлалын мэдээлэл", УБ.,1996, №1-2, (17,18), 194-196.
4. У.Гонгоржав, Монголын эртний харвуул, тэмцээн, УБ., 1982, 79 тал.
5. Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм, УБ., 1957, (158 тал), 34-35; 1999, (264 тал), 49-52.
6. Д.Жамсранжав, "Буха сужигай" гэдэг нэрийн учир, "ОУМЭ-ий IV их хурал", I боть, УБ., 1985 (84), 455-458.
7. Д.Жамсранжав, Чулуун ном, № 1, УБ., 2003, (109 тал), 13-26, 89.
8. Д.Кара, Книги монгольских кочевников, М., 1972, (194 сс), 56-57.
9. С.В.Киселев, Древнемонгольские города, М., 1969, 53-57.
10. И.Клюкин, Древнейшая монгольская надпись на Хорхираском ("Чингисхановом") камне, "Труды Гос. Дальневосточ. Ун-Та", Серия, VI. №5, Владивосток, 1927, 38 сс.
11. С.Комаров, Процесс о монгольской надписи на памятнике Чингис-хана, "Отеч.зап", 1839, Т.7, 27-33.
12. Ц.К.Корсункиев, Еще раз к дешифровке надписи на так называемом Чингисовом /Хирхиринском/ камне, ХЗС, t.XV, УБ., 1982 (80), 62-72.
13. Ж.Надмид, Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм, УБ., 1967, (131 тал), 32-37.
14. О.Намнандорж, Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай, УБ, 1956, (28 тал), 3-6.
15. А.М.Позднеев, Лекции по историй монгольской литературы, Т. I, 1896, (240 сс), 51-79.
16. Х.Пэрлээ, Гурван өгүүлэл, SM, t.III, f. 13-15, УБ., 1962, (48 тал), 3-23.
17. В.Э.Раднаев, О надписи на стеле Исунггэ (история дешифровки: спорное и бесспорное), "Монгольский лингвистический сборник", М., 1992, 94-98.
18. И.де Рахевилз, Есүнгийн чулууны бичгийн талаарх зарим тэмдэглэл, (Орч.М.Саруул-Эрдэнэ), МХШ, (УБИС), №3, 2000, 123-132.
19. Г.И.Спасский, Древности Сибири, "Сибирский вестник", 1818. часть IV. Отд II. 116-124
20. Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал), 301.
21. Д.Цэнд, XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалаас, ХЗ, t.II, УБ.,1964, (тал. 3-52), 16-22.
22. Ц.Шагдарсүрэн, Монгол үсэг зүй, УБ., 1981, (168 тал), 13.
23. Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2002, (300 тал), 49.

24. И.Я.Шмидт, О новом переводе монгольской надписи на известном памятнике Чингисхана, "Санктпетербургские ведомости", 1839, №224.
25. И.Я.Шмидт, Процесс о монгольской надписи на памятнике Чингисхана, "Отечественные записки", 1839, T.7, 27-33.
26. Bousiyang, Mongγol üsüg bičig-ün uqaγan, ÖMSKKQ, 1984, (222 tal-a), 69-70.
27. Danzan, Uyiγurjin mongγol bičig, "Erdem sinjilegen-ü ögülel-üd", 1990, (71-175 tal-a), 101-104.
28. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 1-7.
29. Ji. Jirannige, Činggis-ün čilaγun-u bičigesü-yin tuqai, MKB, 1984, №3, 34-40.
30. Norbu, Činggis-ün čilaγun-u bičig-ün sudulul, "Mongγol kele udq-a jokiyal-un sinjilegen", 1981, №2, 1-35.
31. Norbu-odcar, Činggis-ün čilaγun-u bičig-ün tuqai sudulul, "Öber mongγol-un ündüsüten-ü baγsi-yin degedü suryaγuli-yin erdem sinjilegen-ü bičig", 1983, №1, 1-20.
32. Sayisiyal, Činggis-ün čilaγun-u bičig, MKB, 1980, №3, aru niγur.
33. H.C.v.d. Gabelentz, Versuch über eine altemongolische Inschrift, ZKM, 1839, Bd.II, H.1, 1-21.
34. P.Aalto, Von M.A.Castrén aufgezeichnete mongolische Inschriften "Collectanea Mongolica. Festschrift für Dr.Rintchen zum 60. Geburtstag", AF, 17, Wiesbaden, 1966, 1-7.
35. L.Hambis, À propos de la "Pierre de Gengis khan", "Mélanges publiés par l'Institut des Hautes Études chinoises", vol. XIV, t. II, Paris, 1960, 141-157, 1pl.
36. W. Kotwicz, (Review in polish), I.Klukin, The most ancient mongolian inscription on the Kharkhira (Chingis Khan) stone, (Mémoires de l' Université d'État à l'Extrême-Orient. sér. YI:5), Vladivostok, 1927. RO, t. YII (1929-1930), 1931, 195-197.
37. L.Ligeti, Preklasszikus emlékek I, MN. I, Budapest. 1963, (176pp), 15-16.
38. L.Ligeti, Monuments préclassiques. 1 (XIIIe et XIVe siècles), IVLMMT, Budapest, 1970, (169 pp.), 7-8.
39. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 17-18.
40. S.Murayama, Über die Inschrift auf dem "Stein des Čingis", Or, Bd. III, 1950, 108-112.
41. I. de Rachewiltz, Some Remarks on the Stele of Yisüngge, "Tractata Altaica, Denis Sinor Sexagenario Optima de Rebus Altaicis Merito Dedicata", Redigerunt Walther Heissig, John R. Krueger, Felix J. Oinas, Edmond Schütz, Wiesbaden, 1976, (XI+775 pp), 487-508.
42. W. Radloff, Atlas der Altertümer der Mongolei, St. Pbg., 1892, XLIX, pl.3.V.
43. Rinčen, L'inscription sinomongole de la Stèle en l'honneur de Möngke qaγan, CAJ, IV, 1958, 130-143, fig.6.
44. I.J.Schmidt, Bericht über eine Inschrift aus der ältesten Zeit der Mongolian-Herrshaft, Mém. de.l'Ac. de Sciences de St.Pbg. VI^{e} serie, vol. II, 1834, 243-256.
45. W. Schott, Ueber Bansarow's Auslegung einer mongolischen Inschrift, "Archiv für Wissenschaftliche Kunde von Russland", Bd. 14, n.2, Berlin, 1855.

II.2. Төрэгэнэ хатны зарлигийн бичээс (1240)

БНХАУ-ын Хэнань мужийн Жи Юань (济源县) сианы "Арван зүгийн их Зи Вэй-гүн" (十方大紫微宫) хэмээх сүмд энэхүү гэрэлт хөшөө хадгалагдаж байна. Уул хөшөөнөө 10 мөр нангиад бичээсийн хамт зарлигийн гол санаа, огноог тэмдэглэсэн 3 мөр, 15 үг бүхий монгол бичээс сийлсэн буй.

1. Д.Жамсранжав, Өгэдэй хааны зарлигт хөшөөний бичээс, "Монгол судлалын мэдээлэл", УБ., 2002, №1(29), 2(30), 136-139.
2. Д.Жамсранжав, Чулуун ном, № 1, УБ., 2003, (109 тал), 27-46, 90.
3. Danzan, Uyiγurjin mongγol bičig, "Erdem sinjilegen-ü ögülel-üd", 1990, 101-104.
4. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 8-12.
5. Qaserdeni, Arban jüg-ün yeke ci vei gung süm-e-deki 1240 on-u kösiyen-ü mongγol bičig-ün tuqai sinjilege, MKB, 1984, №2, 26-33.
6. F.W.Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1240, HJAS, vol. 23, №1-2,1960-61, 62-75, pl. I-II.

7. L.Ligeti, 1. Preklasszikus emlékek I, MN. I, Budapest. 1963, (176 pp), 17.
8. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, I, Budapest, 1970, (169 pp.), 9.
9. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 19.
10. I.de Rachewiltz, Some Remarks on Töregene's Edict of 1240, PFEH, vol.23, (March, 1981), 39-63, 1pl.
11. I. de Rachewiltz, Was Töregene Qatun Ögödei's 'Sixth Empress', "ОУМЭ-ий VIII их хурал", "Mongolica. An International Annual of Mongol Studies", vol. 10 (31), 2000, 441-460.
12. 蔡美彪,元代白话碑集录,北京,1955,pl.II.
13. 蔡美彪,脱列哥那后史事考辨, "蒙古史研究", 1989, № 3, 12-29.

III.3. Гүюг хааны тамгын бичиг (1246)

Өгэдэй хааны хүү Гүюгээс Ромын пап IV Инноцентэд илгээсэн перс хэлээрхи захидал дээр 2 удаа дарсан 6 мөр, 15 үг бүхий тамгын бичиг эдүгээ Ватиканы нууц архивт хадгалагдаж байна.

1. Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм, УБ., 1957, (158 тал), 35, 1999, (264 тал), 52-53.
2. Д.Жамсранжав, Чулуун ном, № 1, УБ., 2003, (109 тал), 47-58, 91-95.
3. Д.Цэнд, XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалаас, ХЗ, t.II, УБ.,1964, (3-52), 22-23.
4. Д.Төмөртогоо, Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд, УБ., 2002, (549 тал), 310.
5. Ц.Шагдарсүрэн, Монголчуудын үсэг бичигийн товчоон, УБ., 2002, (300 тал), 50.
6. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 13-18.
7. L.Ligeti, 1. Preklasszikus emlékek I, MN. I, Budapest. 1963, (176 pp), 18.
8. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, I, Budapest, 1970, (169 pp.), 10.
9. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 20.
10. A.Mostaert, F.W.Cleaves, Le Sceau du grand khan Güyüg, HJAS, t.XV, № 1-2, 1952, 485-495, (Appendice II of their article "Trois document mongols les Archives Vaticanes")
11. P.Pelliot, Les Mongols et la Papauté, "Revue de l'orient Chrétien", 3-e série, t. III (XXIII), №1 et 2, (1922-1923), Paris, 1923, 3-30.
12. I. de Rachwiltz, Qan, Qa'an and the Seal of Güyüg, "Documenta Barbarorum, Festschrift für Walther Heissig zum 70. Geburtstag", Hrsg. von Klaus Sagaster und Michael Weiers. Veröftentlichungen der Societas Uralo-Altaica, Band 18, 37, 1983, 272-281.
13. 照那斯图,蒙元时期宫廷文书的印章文字,民族语文,1997, №3, 43-50+12pl.(resp.43-44,pl.2).

IV.4. Мөнх хааны гэрэлт хөшөө (1257)

Нийт 3 мөр, 18 үг бүхий энэхүү бичээсийг Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг, Дэлгэрхааны өвөр, Дэлгэр мөрний хойт хөвөө, Алтангадас гэдэг бяцхан хадат уулын араас эрдэмтэн О.Намнандорж 1953 онд олсон бөгөөд эдүгээ Үндэсний Түүхийн музейд хадгалагдаж байна.

1. Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм, УБ., 1957, (158 тал), 35-36; 1999, (264 тал), 53-54.

2. Ш.Ёнхор, Мөнх хааны гэрэлт хөшөөний монгол бичгийг дахин уншсан нь, "УИС ийн манж-монгол хэлний ангийн оюутнуудын эрдэм шинжилгээний бичиг", УБ. 1962(3), 59-67.
3. Д.Жамсранжав, Чулуун ном, № 1, УБ., 2003, (109 тал), 59-72, 96-100.
4. О.Намнандорж, Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай, УБ, 1956 28 тал.
5. О.Намнандорж, Мөнх хааны гэрэлт хөшөөний хятад бичгийн тухай, ШУ, 1960, №5 "О. Намнандорж" (Бүтээлийн түүвэр), II боть, (552 тал), 437-439.
6. А.Очир, Мөнх хааны гэрэлт хөшөөний монгол бичээс, "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал", УБ., 1999, (286 тал), 219.
7. Д.Цэнд, XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалаас, ХЗ, t.II, УБ.,1964, (тал. 3-52), 23-27.
8. Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал), 301-302.
9. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 19-23.
10. L.Ligeti L.Ligeti, 1. Preklasszikus emlékek l, MN. I, Budapest. 1963, (176 pp), 19.
11. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, I, Budapest, 1970, (169 pp.), 11.
12. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 21.
13. N.Poppe, Notes on the Monument in Honour of Mönke Khan, CAJ, vol.VI, 1961, 14-18.
14. Rinčen, L'inscription sinomongole de la stèle en l'honneur de Möngke qaγan, CAJ, IV, 1958, 130-143+6 photos.
15. Rintchen, Les designs pictographiques et les inscriptions les rochers et sur les steles en Mongolie, CSM, t.XVI, f. 1, УБ., 1968, (77 pp), 75.
16. 胡斯振,白翠琴, 1257 年釈迦院碑考釈, "蒙古史研究", 1985, 第 1 輯, 11-20.
17. 宇野伸浩, 松川節,中村淳, 釈迦院碑記, "モンゴル国現存遺蹟・ 碑文調査研究報告", 責任編集 森安孝夫・ オチル,中央ユーラシマ学研究会, 1999 年 3 月, 254-260.

V.5. Хархорумын I бичээс (1346)

Эрдэнэзуу хийдийг байгуулсан үйл явдлыг өгүүсэн эл хөшөөний бичээс Өвөрхангай аймгийн Эрдэнэзуу хийдийн нутаг дэвсгэрт байсан бөгөөд эвдэрч гэмтээд, дөрөвхөн хугархай хэсэг олдсон бол эдүгээ гурав нь үрэгдэж дундуураа хоёр хугарсан нэг хэсэг нь л Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн олдворын сан хөмрөгт хадгалагдаж байна.

1. Ж.Гэрэлбадрах, Хар Хорумын нэгдүгээр монгол бичээс, "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал", УБ., 1999, (286 тал), 233-234.
2. Ц.Корсункиев, К дешифровке и переводу на русский язык В.Котвичем написей на камнях из Кара-Корума, ХЗС, t. XIV, 1980(78), 24-30.
3. В.Котвич, Монгольские надписи в Эрдэни-Зу. "Сборник музея Антропологии и Этнографии имени Петра Великого при Российской Академий наук", V. 1918, 205-214.
4. Н.Поппе, Предварительный отчет лингвистической экспедиций в Северную Монголию за 1926 год, (Отчет о поездке на Орхон летом 1926 года), Л., 1929, 1-25.
5. Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал), 303.
6. Ц.Төрбат, Хар Хорумын монгол бичээсийг дахин өгүүлэх нь, "Түүхийн судлал", УБ., 1997, t.XXX, f.1-14, 90-99.
7. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 319-340.
8. F. W. Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1346, HJAS, vol. 15, №1-2, 1952, 1-123, pl. I-XII.
9. L.Ligeti, 1. Preklasszikus emlékek l, MN. I, Budapest. 1963, (176 pp), 20-24.
10. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, I, Budapest, 1970, (169 pp.), 12-26.

11. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 22-26.
12. W. Radloff, Atlas der Altertümer der Mongolei, St. Pbg., 1892, pl.XLI.
13. Rintchen, Les designs pictographiques et les inscriptions les rochers et sur les steles en Mongolie, CSM, t.XYI, f. 1, УБ., 1968, (77 pp), 73.

VI.6. Хархорумын II бичээс (1348)

Өвөрхангай аймгийн Эрдэнэзуу хийдийн ойролцоо, эртний Хархорум хотын тууриас нүүрэн талдаа 22 мөр нангиад бичээс, 5 мөр монгол бичээс, ар талдаа 4 мөр монгол бичээс бүхий хөшөөний хугархай олдсон нь Эрдэнэзуу хийдэд хадгалагдаж байна.

1. Ж.Гэрэлбадрах, Хар Хорумын хоёрдугаар монгол бичээс, "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал", УБ., 1999, (286 тал), 239.
2. F.W.Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1348, HJAS, vol. 27, № 1-2, 1967, 76-102, pl. I-VIII.
3. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, II, Budapest, 1972, (382 pp.), 11-12.
4. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 27.
5. W. Radloff, Atlas der Altertümer der Mongolei, St. Pbg., 1892, pl.XIY, fig.1-2.
6. 松川節, カラコルム出土１３４８年漢蒙碑文, (嶺北省右丞郎中総管収糧 記), "内陸アジア言語の研究", t. XII, 1997, 83-98+1pl..
7. 松川節・ 松井太, 嶺北省右丞郎中総管収粮記, "モンゴル国現存遺蹟・ 碑文調査研究報告", 贇任編集 森安孝夫・ オチル,中央ユーラシマ学研究会, 1999 年 3 月, 245-251.

VII.7. Хархорумаас шинээр олдсон бичээс

2003 оны зун Монгол-Германы шинжилгээний анги Өвөрхангай аймгийн Хархорин сумын Эрдэнэзуугийн хэрэм доторх цогчин дуганы туурийг ил гаргах явцад нэгэн баганын суурь чулуун дээр нэг талдаа 13 мөр монгол, нөгөө талдаа 9 мөр нангиад бичээс байгааг илрүүлсэн бөгөөд уул дурсгал эдүгээ Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт хадгалагдаж байна. Одоо уул хөшөөний бичээсийг монголын эрдэмтэд уншин судалж байгаа болно.

VIII.8. Богд уулын бичээс

Богд уулын Их тэнгэрийн амны хаднаа сүг зураг болон XIII-XIV зууны үед хамаарах хар бэхээр үйлдсэн цөөн мөр бичээс байдаг билээ.

1. Ц.Дамдинсурен, Древнемонгольские надписи на скале у подножия горы Богда ула. "Материалы по истории и филологии Центральной Азии", ТБКНИИ, Выпуск 8, 1962, 176-180.
2. П.Окладников, Древнемонгольский портрет, надписи и рисунки на скале у подножия гору Богдо-уула, "Монгольский археологический сборник", М.,1962, 68-74.

IX.9. Хүйтэн голын бичээс

Дархан хотоос зүүн хойш 70 километрт Хүйтэний голын Бичигт хошуу хэмээх газар буй. Хүйтэний гол руу зүүн талаасаа түрж орсон өндөр хадан хошууны гол руугаа шахсан үзүүрийн ханан хадны хөмөгт хар бэхээр бичсэн 11 мөр уйгуржин монгол, 9 мөр дөрвөлжин үсгийн бичээс байдаг нь он цагийн урсгалд нэлээд балархайшин мууджээ. Монгол, дөрвөлжин хоёр бичээс нэгэн үед буюу XIII-XIV зууны орчим бичигдсэн болох нь илэрхий байна.

1. Л.Галсанцэрэн, Хүйтэн голын хадны бичээс, МХШ, t.Y(XXVII), Уб., 1999, 216-221.
2. А.Очир, Хүйтэн голын монгол ба дөрвөлжин бичгийн дурсгалуудын тухай, "ОУМЭ-ий VII их хурал. Илтгэлүүдийн товчлол ", УБ., 1997, 117-119; "Mongolica, An International Annual of Mongol Studies", vol.11(32), 2001, 93-97.
3. Н. Сэр-Оджав, А. Очир, Г. Гантогтох, Сэлэнгэ аймгийн Хүйтэний голын районд 1983 онд явсан монгол бичээс судлалын хээрийн шинжилгээний ангийн урьдчилсан тайлан: Хархорум, Хархул хааны балгасыг малтсан тайлан. ШУА, Түүхийн Хүрээлэн, Археологи Этнографийн тасаг, УБ., 1982 (sic!).
4. 中村淳· 松川節· 松井太, フイテンニゴル岩壁銘文, "モンゴル国現存遺蹟· 碑文調査研究報告", 責任編集森安孝夫· オチル,中央ユーラシマ学研究会, 1999 年 3 月, 266-268.

X.10. Бүрэгхангайн бичээс

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь Бичигтийн хадан хошуунаа хар бэхээр бичсэн 7 бүлэг, 50 шахам мөр монгол бичээс, мөн 7 мөр нангиад бичээс тус тус байдаг ажээ.

1. Д.Боролзой, Бичигтийн нууц. УБ. 1998, 48 тал.
2. Х.Лувсанбалдан, Шинжилгээний ангийн өдрийн тэмдэглэлээс, ШУА, 1967, №6, 43-44.

XI.11. Тайхар чулууны бичээс

Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Хойд Тамирын голын хөвөөнөө орших Тайхар чулуу хэмээх сүрлэг сайхан хадан цохионоо олон зуун жилийн турш тэмдэглэсэн сүг зураг, тамга тэмдэг болон руни, нангиад, согд, уйгур, ланз, төвд, манж, монгол, дөрвөлжин*, тод зэрэг олон зүйл үсгээр үйлдсэн 150 гаруй бичээс буй. Эдгээрээс хамгийн олон тоотой нь монгол бичиг бөгөөд 70 орчим бичээс байна.

Монгол бичээсийн дотор хамгийн эртнийх нь хар бэхээр үйлдсэн XIII-XIV зууны үед хамаарах монгол бичгийн 10 гаруй мөр бичээс баруун хойд буланд нэлээд доор бичигдсэн байдаг. Уул бичээс нь олон зуун жилийн турш байгалийн элдэв үзэгдлийн нөлөөгөөр ихээхэн балархайшиж муудсан тул тайлан уншихуйяа нэн бэрх болсон байна.

---

* 2004 оны 6-р сарын 17-ны өдөр МУИС-ийн МХСС-ийн Түрэг судлалын III ангийн оюутнуудын хээрийн дадлагыг удирдаж явахдаа (Доктор Ц.Баттулга, судлаач багш Р.Мөнхтулга, Н.Гэрэлмаа нарын хамт) бид Тайхар чулуунаа нэг мөр дөрвөлжин үсгийн дурсгал байсныг шинээр нээн илрүүлсэн билээ. Ё.Жанчив, Л.Батбилиг, Тайхар чулууны дөрвөлжин бичиг, "Түүхийн сэтгүүл, Emphemeris Historiae, Academia Doctrinae Mongoli", t.Y, УБ., 2005 (хэвлэлд) өгүүллээс лавлана уу.

1. Ж.Гэрэлбадрах, Тайхар чулууны монгол бичээс, "Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал", УБ., 1999, (286 тал), 222-223.
2. Х.Пэрлээ, Тайхир чулуу, SA. t.I, УБ.,1960 , 26 тал.
3. Rintchen, Les designs pictographiques et les inscriptions les rochers et sur les steles en Mongolie, CSM, t.XYI, f. 1, УБ., 1968, (77 pp), 72.

XII. 12. Бичигт Хангайн бичээс

Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт Бичигт хангай хэмээх төвд, монгол, уйгур, ланз бичээс бүхий хадан хясаа буй. Эдгээрээс хамгийн олон тоотой нь төвд, монгол бичээс болно. Энэхүү хадан хошууны баруун захын хойшоо харсан хадан хясааны доод хөмөгт хар бэхээр үйлдсэн 10 мөр, 24 үгтэй уйгуржин монгол бичээс байдаг. Үүнийг ажиглан тэмдэглэж, тайлан уншсан зүйл одоо хир үгүй бололтой.

1. Л.Тэрбиш, Ц.Баттулга, Бичигт хангайн монгол, төвд бичээс, "Түүхийн сэтгүүл. Emphemeris Historicae, Academia Doctrinae Mongoli", t.IC, f.1-23, Уб., 2003, 40-44.

B. Хятад

XIII. БНХАУ-ын Хэнань мужийн Шао-лин хийдийн гэрэлт хөшөөний бичээс

Хятад улсын Хэнань (河南) мужийн Дэн-фэн (登封县) сианы Шао-лин (少林) хийдээс 1980-аад оны эхээр чулуун яст мэлхий суурьтай нэг талдаа уйгуржин монгол бичгийн гурав, дөрвөлжин үсгийн нэг, нөгөө талдаа хятад бичээс бүхий гэрэлт хөшөө олдсон байна. Монгол бичээсийг доор авч үзвэл:

13. Мөнх хааны зарлигийн бичээс (1253)
    Энэ нь нийт 15 мөр, 86 үгтэй бичээс болно.
14. Хубилай хааны зарлигийн бичээс (1261)
    Энэ нь нийт 39 мөр, 249 үгтэй бичээс болно.
15. Хубилай хааны зарлигийн бичээс (1268)
    Энэ нь нийт 49 мөр, 252 үгтэй бичээс болно.

1. 道布,照那斯图,河南登封少林寺出土的回鹘式蒙古文和八思巴字圣旨碑考释, 民族语文,1993, № 5,1-3, № 6,59-71+2pl,1994, № 1,32-40+2pl.
2. 中村淳· 松川節, 新発見の蒙漢合璧少林寺聖旨碑, "内陸アジア言語の研究", 1993, YIII, 1-92, +8pl.

XIV. 16. Жибинтөмөр вангийн гэрэлт хөшөөний бичээс (1277)

БНХАУ-ын Шаньси (陕西) мужийн Ху (户县) сианы төв Гуань (关) хотоос 10 километр зайд орших Чун-Ян-Гун (重阳宫) хэмээх бомбын сүмд Юань улсын үеийн монгол-нангиад үсгээр бичсэн Жибинтөмөр вангийн гэрэлт хөшөө буй. Уул хөшөөний магнайд дөрвөлжин үсгээр нангиад хэлээр бичсэн 2

мөр бичээс байх бөгөөд хөшөөний уйгуржин монгол бичээс нь 23 мөр, 164 үгтэй ажээ.

1.道布,照那斯图,刘兆鹤,回鹘是蒙古文只必帖木儿大王令旨释读, 民族语文,1998, № 2, 9-17+2pl.

XV. Дунхуангийн агуйн дурсгал

БНХАУ-ын Ганьсу мужийн нутагт орших Дунхуангийн (敦煌) агуйн хананд олон арван бурханы хөрөг хийгээд 30 орчим монгол бичээс байдаг ажгуу. Түүнчлэн тус агуйгаас цаасан дээр тэмдэглэсэн дурсгалын тасархай ч олджээ.

17. Төлөг Төгсийн бичээс (1323)

Дунхуангийн 144 дүгээр агуйн хонгилийн хойд хадан дахь баруунаасаа нэгдүгээрх буян үйлдэгчийн зурмал хөргийн баруун дээд талд хар бэхээр үйлдсэн нийт 9 мөр, 34 үг бүхий бичээс буй.

1. Qaserdeni, Гarudi, Dünquvang-un müve you kü-deki yuvan ulus-un üy-e-yin uyiγurjin mongγol bičig-ün Töleg Tegüs-ün bičigesü-yi ungsiγsan ni, ÖMNSU, 1988, №4, 81-89, <<敦煌研究>>, 1987, №3, 43-48+1.
2. W. Kotwicz, Quelques données nouvelles sur les relations entre les Mongols et les Ouigours. RO, t.II, 1926, 240-247.
3. L.Ligeti, Preklasszikus emlékek l, MN. I, Budapest. 1963, (176 pp), 38.
4. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, II, Budapest, 1972, (382 pp.), 13-15.
5. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 33-34.
6. Mission Pelliot I.Les grottes de Touen-houang, Tome premier, grottes là 20, Paris, 1920, pl.XII.

18. Хос мөрт шүлэг

Нийт 2 мөр, 9 үгтэй модон барын тасархайг анх Францын нэрт монголч, нангиадч профессор П.Пеллио олж мэдээлжээ.

1. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, II, Budapest, 1972, (382 pp.), 13-15
2. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 35.
3. P.Pelliot, TP, t.XXV, 1927, 148.
4. P.Pelliot, Neuf notes sur des questions d'Asie Centrale, TP, vol. XXVI, 1928, 219.

19. Дунхуангийн агуйгаас олдсон хэдэн хуудас барын судрын тасархай

Дунхуангийн агуйгаас олдсон 3 хуудас хууль цаазын бичгийн тамтархай Өвөрмонголын эрдэмтэд олж судалжээ.

1. Bürinbatu, Dünquvang-un öb bičig doturaki kedün qayudasu uyiγurjin mongγol üsüg-ün durasqal-i šinjilekü ni, "Kele bičig, 语文 language, Öbür mongγol-un yeke suryayuli-yin qoyaduγar udayan-u mongγol sudulul-un olan ulus-un erdem sinjilegen-ü yarilčaqu qural", Köke qota, 1991, 8-9 sar-a, 1103-1110.

20. Бусад дурсгал

Дунхуангийн агуйн хананд 30 шахам монгол бичээс, мөн тус агуйгаас өөр бусад ном судрын тасархай олдсоныг БНХАУ-ын эрдэмтэд судлан нийтлүүлсээр байна.

1. С.Гарди, Дунхуаны агуй дахь монгол бичиг дурсгалын ерөнхий байдал, "Mongolica, An International Annual of Mongol Studies", Vol.14 (35), 2004, 111-115
2. Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал.), 302.
3. Engkebayatur, Dünquvang-un müve γou kü ayui-yin 61-düger ayui-daki Temür Buq-a-yin bičigesü-yi ungsiγsan ni, "Soyul erdem-ün sudulul", ÖMSKKQ, 1994, 132-144.
4. Гarudi, Bayanbayatur, Lüve quvan čing, Dünquvang-un ayui-nuyud-taki uyiγurjin mongγol bičigesün-ü erdem sinjilegen-ü medegülülte, "ÖMBYS-yin erdem sinjilegen-ü sedkül", 1995, №4, 117-138, <<敦煌研究>>, 1990, №4, 1-19+5 зураг.
5. Qaserdeni, Гarudi, Dünquvang-un müve γou kü-deki yuvan ulus-un üy-e-yin uyiγurjin mongγol bičig-ün Töleg Tegüs-ün bičigesü-yi ungsiγsan ni, ÖMNSU, 1988, №4, 81-89, <<敦煌研究>>, 1987, №3, 43-48+1.
6. Qaserdeni, Гarudi, Bayanbayatur, Müve γou kü-deki 61-düger ayui-yin qonggil-un emün-e qan-a-daki uyiγurjin mongγol bičig-ün bičigesü-yi ungsiγsan ni, "ÖMBYS-yin erdem sinjilegen-ü sedkül", 1989, №4, 1-7+1 зураг.
7. Qaserdeni, Гarudi, Bayanbayatur, Ansi-yin iui lin kü ayui-yin 12 duγar ayui-yin qonggil-un qoyidu qanan-daki uyiγurjin mongγol bičigesü-yi ungsiγsan ni, <<敦煌研究>>,1990, №3, 107-110+1 зураг.
8. Qaserdeni, Гarudi, Bayanbayatur, Ansi-yin iui lin kü ayui-yin 12 duγar ayui-daki Dorji-yin bičigesü-yi ungsiγsan ni, <<敦煌研究>>, 1992, №2, 5-7+1.
9. Qaserdeni, Гarudi, Bayanbayatur, Ansi-yin iui lin kü-deki Madi-yin bičigesü-yi ungsiγsan ni, <<敦煌研究>>, 1993, №1.

XVI. 21. Чан Йин-жүйн гэрэлт хөшөөний бичээс (1335)

БНХАУ-ын Өвөр Монголын Улаанхад хотоос хойш 160 газрын зайтай орших Гуо Гүн-фэнь (国公坟) хэмээх газарт Чан Йин-жүй болон түүний урьдас хойчсын гавьяа зүтгэлийг магтсан бичээс бүхий гэрэлт хөшөө байдаг ажээ. Уул хөшөөний магнайн бичээс нь нангиад хэлээр дөрвөлжин үсгээр үйлдсэн 4 мөр бөгөөд уйгуржин монгол бичээс нь 57 мөр, 1500 гаруй үгтэй юм.

1. Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал.), 302.
2. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 212-268.
3. Гarudi, "Jang ying-šüi-yin kösiy-e"-yin mongγol bičig-ün sudulul, (nige), "Erdem sinjilegen-ü ögülel-üd", ÖMAKQ, 1990, 344-499.
4. Sečenbayatur, "Jang ying-žüi-yin kösiy-e" kiged tegün-dü qolbuγdaqu jarim asaγudal, ÖMNSU, 1983, №3, 122-128.

5. F.W.Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1335 in Memory of Chang Ying-jui, HJAS, vol.13, № 1-2, 1950, 1-131, pl.I-XXXV.
6. F.W.Cleaves, Aldar Čab-Čab Aldar, HJAS, vol.18, № 1-2, 1955, 221-233.
7. L.Ligeti, 1. Preklasszikus emlékek l, MN. I, Budapest. 1963, (176 pp), 44-58.
8. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, I, Budapest, 1970, (169 pp.), 81-130.
9. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 36-50.
10. 田村實造,烏丹城 附近に元碑を探る, "蒙古学", 1937, 68-82+2pl.

XVII. 22. Жигүнтэйн гэрэлт хөшөөний бичээс (1338)

БНХАУ-ын Өвөр монголын Онниуд хошууны Бор хотоос урагш 7 газрын зайтай газарт даргач Жигүнтэйн гавьяа зүтгэл, сайн үйлсийг магтсан гэрэлт хөшөө байдаг байна. Уул хөшөөний магнайн бичээс 3 мөр уйгуржин монголоор бичигдсэн бөгөөд уг хөшөөний бичиг нь 37 мөр, 1200 гаруй үгтэй юм. Энэ хөшөө эдүгээ алга болсон сурагтай.

1. Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал.), 302.
2. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 269-306.
3. F.W.Cleaves, The Sino-Mongolian Inscription of 1338 in Memory of Jigüntei, HJAS, vol.14, № 1-2, 1951, 1-104, pl.I-XXXII.
4. F.W.Cleaves, tomuγ-a/ t'o-mu-hua, HJAS, vol.17, № 3-4, 1954, 445-452.
5. L L.Ligeti, 1. Preklasszikus emlékek l, MN. I, Budapest. 1963, (176 pp), 59-66.
6. L.Ligeti, Monuments préclassiques. 1(XIIIe et XIVe siècles), IVLMMT, I, Budapest, 1970, (169 pp.), 131-160.
7. L.Ligeti, Monuments préclassiques 1.(XIIIe et XIVe siècles) MLMC II, Budapest, 1972, (296 pp), 51-58.
8. 田村實造,烏丹城 附近に元碑を探る, "蒙古学", 1937, 68-82+2pl.

XVIII.23. Аруг вангийн гэрэлт хөшөөний бичээс (1340)

БНХАУ-ын Юннань мужийн Куньмин хотын Юй ань-шань (玉案山) хэмээх уулын дээр орших Чиун-жу-си (筇竹寺) хэмээх эртний сүмд Аруг вангийн гавьяа зүтгэл хийгээд Ганжуур номыг дэлгэрүүлэх тухай дурдсан хөшөө байдаг ажгуу. Уул хөшөөний магнайд дөрвөлжин үсгээр нангиад хэлээр бичсэн 2 мөр байх бөгөөд хөшөөний уйгуржин монгол бичээс нь 20 мөр, 251 үгтэй юм.

1. Х.Лувсанбалдан, Аруг вангийн хөшөөний бичиг, "Дандины "Зохист аялгууны толь" ба түүний тайлбарын тухай товч мэдээ ", SM, t. IV, f.6, УБ., 1962, 123-136, 1 зурагтай.
2. Д.Төмөртогоо, "Монгол хэлшинжилэлийн онол, түүхийн асуудлууд", УБ., 2002, (549 тал.), 302-303.
3. Bousiyang, 1340 on-u Künming-deki mongγol kösiyen-ü bičig-i dakin tayilburilan ungsiγsan ni, "Ündüsüten-ü kele bičig", 1980, №4, 43-51.
4. Bousiyang, Künming-deki 1340 on-u mongγol kösiyen-ü bičig-i dakin ungsiγsan ni, MKUJ, 1980, №1, 38-50.
5. Bousiyang, Mongγol üsüg bičig-ün uqaγan, ÖMSKKQ, 1984, (222 tal-a), 70-92.
6. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-iyer bičigsen "Yün nan vang γanjuur nom-i delgeregülkü-yin kösiyen"-ü sinjilel, MKB, 1979, №2, 14-21.

7. Dobu, Uyiγurjin mongγol üsüg-ün durasqaltu bičig-üd, ÜKQ, 1983, (695 tal-a), 305-316.
